# ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН СҮМБЭР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙГ 2022 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ

**/эхний хагас жилээр/**

2022.06.08 Сүмбэр

| № | Зорилт | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Хүрэх түвшин, үр дүн /хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр сая.төг/ | Хэрэгжилт үр дүн | Үнэлгээ |
|---|---|---|---|---|---|---|
| **НЭГ. "КОВИД-19" ХАЛДВАРТ ЦАР ТАХЛААС ҮҮДЭЛТЭЙ ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ХҮНДРЭЛИЙГ ДАВАН ТУУЛАХ БОДЛОГО** | | | | | | |
| 1 | 1. Ковид-19" халдварт цар тахлаас үүдэлтэй эдийн засаг, нийгмийн хүндрэлийг даван туулах бодлогын арга хэмжээг хэрэгжүүлнэ | 1.1 Ковид-19" халдварт цар тахлаас үүдэлтэй эдийн засаг, нийгмийн хүндрэлийг даван туулах аймаг орон нутгийн бодлогын арга хэмжээг хэрэгжүүлнэ | Хэрэгжилтийн хувь | Хүнс тэжээлийн дэмжлэг шаардлагатай хүүхэд, өрх, хүн амын судалгаа мэдээллийг нарийвчлан гаргах, уг ажиллагаанд төрийн болон төрийн бус байгууллагуудын оролцоог хангаж ажиллана. | Сумын хэмжээнд хүнсний эрхийн бичигт хамрагддаг 98 өрхийг хяналтад хамруулан хөдөлмөр эрхлэх боломжтой, өрхийн ам бүл цөөн 20 өрхийг хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнээс хасах саналыг амжиргаа дэмжих зөвлөлөөр хэлэлцэн шийдвэрлэж 78 өрхийг хүнсний эрхийн бичигт хамруулаад байна..<br>**Хүрсэн түвшин: Хэрэгжилтийн хувь-100** | 100 |
| 2 | | 1.2 "Ковид-19" халдварт цар тахлын эрсдлээс урьдчилан сэргийлж, бэлэн байдлын хариу арга хэмжээг шуурхай зохион байгуулах | Хэрэгжилтийн хувь | Хариу арга хэмжээний төлөвлөгөө боловсруулна.<br>Цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх үйл ажиллагаанд иргэн, аж ахуй нэгж байгууллагын эзэмшлийн эд хөрөнгө барилга байгууламжийг дайлчилна .<br>Түр хамгаалах байрыг тодотгож, | Аймгийн онцгой комиссын 03,04-р албан тоотын хүрээнд 01-р сарын 13-наас 02-р сарын 15-ны хугацаанд хариу арга хэмжээний төлөвлөгөө гарган батлуулсаны дагуу олон нийтийг хамарсан сургалт, хурал, урлаг соёл спортын арга хэмжээ, уралдаан тэмцээн зохион байгуулахгүй байх, албан байгууллага, худалдаа, үйлчилгээний газарт халдвар хамгааллын дэглэм мөрдүүлж ажиллах үүрэг чиглэлийг худалдаа үйлчилгээний 36 газарт өгч, халдвар хамгааллын дэглэм сахиулах, ил задгай худалдаа хийлгэхгүй байх талаар заавар зөвлөмж өгч ажилласан.<br>Аймгийн онцгой комиссын шуурхай штабт 2 удаа жижүүрийн үүрэг гүйцэтгэсэн. Ойрын хавьтлын талаар иргэдээс мэдээлэл, | 80 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | тохижуулах арга хэмжээ авна. | судалгаа авч тандалтын багт өгч, явуулын халдвар илрүүлэх сорьц шинжилгээг 5-р багт хийж ажилласан.<br>**Хүрсэн түвшин: Хэрэгжилтийн хувь -80** | |
| 3 | | 1.3 "Ковид-19" цар тахлын халдвараас урьдчилан сэргийлэх мэдээ мэдээллийг иргэдэд шуурхай хүргэнэ. | Гэрээ байгуулсан байгууллагын тоо<br>Гүйцэтгэлийн хувь | Орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтран ажиллана. Цахим мэдээлэл сурталчилгааг тогтмолжуулна. | Ковид-19" цар тахлын халдвараас урьдчилан сэргийлэх, Гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэн ажилласантай холбогдуулан ажилтан албан хаагчдыг 10:90 харьцаатайгаар ажлын байранд ажиллуулах, 0-12 насны хүүхэдтэй эмэгтэй албан хаагчдыг цахимаар гэрээсээ ажиллах нөхлийг бүрдүүлэн төрийн үйлчилгээ мэдээ мэдээллийг цахимаар хүргэн, иргэн аж ахуй нэгжээс ирсэн өргөдөл, санал хүсэлтийг цахимаар хүлээн авч шийдвэрлэсэн.<br>Халдвар хамгааллын дэглэм баримталж үйл ажиллагаа явуулах, аймаг сумын онцгой комиссын шийдвэрийг хэрэгжүүлэх үүргийг худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч 34 аж ахуй нэгж байгуулагад хүргэж, төмөр замын вокзал дээр жижиглэн худалдаа хийх 12 иргэнтэй хариуцлагын гэрээ байгуулан мэргэжил арга зүйн зөвлөмж, мэдээлэл өгч,"Ковид-19"-н цар тахлаас урьдчилан сэргийлэх тухай 148 ширхэг гарын авлага, боршур тарааж ажилласан.<br>**Хүрсэн түвшин:**<br>**Гэрээ байгуулсан байгууллагын тоо -12**<br>**Гүйцэтгэлийн хувь -80** | 80 |
| **ХОЁР.ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО** | | | | | | |
| **2.1. Иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлж, урьдчилан сэргийлэх тогтолцоог сайжруулан, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлнэ.** | | | | | | |
| 4 | 2.1 Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх тогтолцоог сайжруулан, оношилгоо үйлчилгээний | 2.1.1 Өрхийн эрүүл мэндийн төвийн эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг давтан сургалтанд хамруулан тогтвор суурьшилтай ажиллуулна. | Сургалтанд хамрагдсан эмч сувилагчийн тоо | Эмнэлгийн албан хаагчдыг давтан сургалтанд 100% хамруулж, тогтвор суурьшилтай ажиллах | Нийгмийн асуудлыг шийдвэрлэж, тогтвор суурьшилтай ажиллуулах зорилгоор багш, өрхийн эрүүл мэндийн төвийн эмч нарт зориулсан 40 айлын орон сууцны барилгын ажлыг эхлүүлэхээр төлөвлөж байгаа бөгөөд гүйцэтгэгч компанитай ажил гүйцэтгэх гэрээг байгуулсан. | 80 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | чанар хүртээмжийг нэмэгдүүлнэ. | | | нөхцлийг бүрдүүлнэ. | | |
| 5 | | 2.1.2 Иргэдэд эрүүл мэндийн тусламж үйлчилгээг чанартай, тэгш, хүртээмжтэй хүргэнэ. | Эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд хамрагдсан иргэдийн хувь | Нийт хүн амын 50%-г урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулна. | ЭМС-ын 2022 оны А/139 дугаар "Хүн амын нас, хүйс, эрүүл мэндийн эрсдэлд суурилсан зонхилон тохиолдох халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх, үзлэг, оншилгоо хийх тухай" тушаалыг хэрэгжүүлэх зорилгоор ЭМГ-аас Аймгийн засаг даргын А/128 дугаар "Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, шинжилгээ оношилгоог зохион байгуулах тухай" захирамж гаргуулан Сүмбэр сумын 0-17 насны нийт 5561 хүүхдийг эрт илрүүлэг үзлэг, шинжилгээ, оношилгоонд хамруулахаар төлөвлөн ажиллаж байна. 2022 оны 05 дугаар сарын 23-ны өдрийн байдлаар 2-17 насны 3275 хүүхдэд урьдчилан сэргийлэх үзлэг хийгээд байна.<br>Халдварт бус өвчний эрт илрүүлэг үзлэг шинжилгээнд эхний 4 сарын байдлаар:<br>• Артерийн даралт ихсэх өвчний эрт илрүүлэгт 18-с дээш насны 7939 иргэн хамрагдахаас 525 иргэн хамрагдаж 6.6 хувьтай,<br>• Чихрийн шижин өвчний эрт илрүүлэг үзлэгт 35-с дээш насны 4621 иргэн хамрагдахаас 529 иргэн хамрагдаж 11.4 хувьтай,<br>• Хөхний хорт хавдрын эрт илүүлэг үзлэг шинжилгээнд 30-60 насны 2515 эмэгтэйчүүд хамрагдахаас 316 эмэгтэй хамрагдаж 12.6 хувьтай,<br>• Умайн хүзүүний хорт хавдрын эрт илрүүлэг үзлэгт 900 эмэгтэй хамрагдахаас 15 эмэгтэй хамрагдаж 1.6 хувьтай<br>Халдварт бус өвчний эрт илрүүлгийн дундаж эхний 4 сард 8.1 хувьтай байна<br>2022 оны эхний 4 сард шинээр тэмбүү өвчний 4 тохиолдол бүртгэгдэж 10 000 хүн амд 2.2, Сүрьез өвчний шинэ тохиолдол 4 бүртгэгдэж 10 000 хүн амд 2.2 байна. | 87 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | **Хүрсэн түвшин: Эрт илрүүлэг үзлэгийн хамрагдалтын хувь 43.5** | |
| 6 | | 2.1.3 Хөдөөгийн багийн иргэдэд 2 удаа эрүүл мэндийн чиглэлээр хөдөлгөөнт үйлчилгээ үзүүлнэ. | Эрүүл мэндийн үйлчилгээнд хамрагдсан иргэдийн хувь | Хөдөөгийн багийн нийт өрхийн 50% /Сумын ОНХС/ | 2022 оны 04 дүгээр сарын 06-07 өдрүүдэд сумын ЗДТГ-аас өрхийн ЭМТ-тэй хамтарсан ажлын хэсэг гарч 4, 5, 6 багийн иргэдэд үзлэг хийсэн. Нийт 89 иргэн үзэж, товлолын вакцин, урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулсан.<br>**Хүрсэн түвшин:**<br>**Зохион байгуулсан арга хэмжээ-1**<br>**Хамрагдсан иргэн- 89** | 100 |
| **Биеийн тамир, спортын салбарт** | | | | | | |
| **2.2.Нийтийн биеийн тамир, эрүүл, идэвхтэй амьдралын хэв маягийг хөгжүүлж, тамирчдын өрсөлдөх чадвар, амжилтыг нэмэгдүүлнэ.** | | | | | | |
| 7 | 2.2 Биеийн тамир, спортын арга хэмжээнд оролцох иргэдийн оролцоог нэмэгдүүлнэ | 2.2.1 Биеийн тамир, спортын уралдаан тэмцээн, үйл ажиллагаанд иргэдийг өргөнөөр оролцуулна | Зохион байгуулах арга хэмжээний тоо<br><br>Хамрагдсан иргэдийн хувь | Биеийн тамир, спортын уралдаан тэмцээн зохион байгуулах тоо – 3 Нийт иргэдийн 20 хувийг хамруулна. /Сумын ОНХС/ | Биеийн тамирын тэмцээн уралдаанд амжилттай оролцох боломжийг бүрдүүлэх зорилгоор спортын 5 арга хэмжээг төлөвлөсөн. Үүнд залуучуудын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх зорилгоор Биеийн тамир спортын газартай заалны гэрээ байгуулж 200 иргэнийг хамруулсан. Олон улсын болон улс бүсийн тэмцээн уралдаанд оролцож буй тамирчдад дэмжлэг үзүүлэх зорилгоор Шатрын холбоотой хамтран Дэлхийн аваргын шатрын тэмцээнд оролцож буй 1 сурагчид 500,0 төг, Зүүн бүсийн аварга шалгаруулах усан сэлэлтийн тэмцээнд оролцож буй 1 тамирчинд 300,0 төг, чөлөөт бүжгийн тэмцээнд оролцсон "Хар сувд" хамтлагт 500,0 дэмжлэгийг тус бүр үзүүлэн ажилласан. Мөн Чойрын богд хайрханы хишиг барилдааныг Монголын Үндэсний бөхийн холбоотой хамтран зохион байгуулсан. Аймаг цэргийн цолтой 256 бөх барилдсан.<br>**Хүрсэн түвшин:**<br>**Зохион байгуулсан арга хэмжээ-2**<br>**Хамрагдсан иргэдийн тоо-456**<br>**Спортоор тогтмол хичээллэсэн иргэдийн хувь -21** | 100 |
| 8 | | 2.2.2 Суманд үйл ажиллагаа явуулж байгаа биеийн тамир | Хамтран ажиллах биеийн тамир | Жилд 3-аас доошгүй биеийн тамир спортын | Биеийн тамир спортын чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй дараах холбоодтой хамтран ажиллалаа. | 100 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | спортын холбоодтой хамтран ажиллана. | спортын холбоодын тоо | хороотой хамтран ажиллана. /Сумын ОНХС/ | 1.Монголын Үндэсний бөхийн холбоотой хамтран Чойрын богд хайрханы хишиг барилдаан<br>2.Говийн усчид клубтай хамтран Зүүн бүсийн аварга шалгаруулах усанд сэлэлтийн тэмцээн<br>3.Сансар хайрхан ширээний теннсиний клубтай хамтран Сумын засаг даргын нэрэмжит Ширээний теннисний тэмцээн<br>4.Ахмадын хороотой хамтран ажилласан.<br>**Хүрсэн түвшин:**<br>**Зохион байгуулсан арга хэмжээ-4**<br>**Хамрагдсан ТББ-ын тоо- 2** | |
| **Боловсролын салбарт** | | | | | | |
| **2.3. Боловсролын үйлчилгээнд тэгш хамруулж, чанар хүртээмжийг сайжруулна.** | | | | | | |
| 9 | Боловсролын үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулна | 2.3.1 Боловсролыг дэмжих арга хэмжээг хэрэгжүүлнэ. | Хүүхдийн суралцах орчин сайжирна | Сургуулийн үдийн цай хөтөлбөрийн тоног төхөөрөмжөөр хангана. | Сургуулийн өмнөх боловсролын хамран сургалт 2021-2022 оны хичээлийн жилд 90, бага боловсролын хамран сургалт 100%, суурь боловсролын хамран сургалт 100% байна. Сургуулийн насны хүүхдийн сургууль завсардалтгүй ажиллаж байна.<br>Шууд худалдан авалтын ажлын хүрээнд 1,2 сургуулийн 11 нэр төрлийн гал тогооны тоног төхөөрөмжийг нийлүүлэхээр "Чиглэл тоног төхөөрөмж", "Тулга төхөөрөмж" ХХК-уудтай 2022 оны 03 сарын 14-ны өдөр гэрээ байгуулсан. Тус ажлыг 2022 оны 03 сарын 31-ны өдөр ажлын хэсгийн бүрэлдэхүүн хүлээн авч 2-р сургуульд 10 нэр төрлийн гал тогооны тоног төхөөрөмж, 1-р сургуульд нержин 2-р хоолны 250 ширхэг тавгийг тус тус хүлээлгэн өгсөн.<br>**Хүрсэн түвшин: Гүйцэтгэлийн хувь-100** | 100 |
| 10 | | 2.3.2 Хувийн хэвшлийн сургууль цэцэрлэгүүдийг бодлогоор дэмжинэ. | Хүүхдийн сурч боловсрох эрх хангагдана | Газрын бодлогоор дэмжинэ. | 2022 онд шинээр сургууль, цэцэрлэг байгуулах санал санаачлага гараагүй. | - |
| 11 | | 2.3.3 Хүүхэд харах үйлчилгээг орон нутагтаа хэрэгжүүлнэ | Хяналт шалгалт зохион байгуулсан тоо | Хуулийн хэрэгжилт хангагдсан байна. | Хүүхэд харах үйлчилгээний тусгай зөвшөөрлийг сумын Засаг даргын 2022 оны 4 дүгээр сарын 12-ны өдрийн А/34 дүгээр захирамжаар 1 жилийн хугацаатай үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг олгосон. Тус | 100 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хүүхэд харах үйлчилгээний төвд 5 хүүхэд хамрагдаж байгаа бөгөөд Сүмбэр сумын 3 дугаар багийн Гашуун 2-1 тоотод үйл ажиллагаа явуулж байна.<br>**Хүрсэн түвшин:**<br>**Хүүхэд харах үйлчилгээний тоо -1**<br>**Хамруулах хүүхдийн тоо-5** | |
| 12 | | 2.3.4 Оюун ухааны сургалтын төвийн үйл ажиллагааг орон нутагтаа хэрэгжүүлнэ. | Газрын бодлогоор дэмжинэ. | Оюун ухааны сургалтын төв бий болно. | Хүүхдийн сэтгэн бодох ой тогтоолтыг сайжруулах зорилгоор "Монголын ухааны академи"-ийг сумандбайгуулан ажиллаж байна. Нийт 6 төрлийн хөтөлбөртэй бөгөөд ой тогтоолт, хуруундай гэсэн үндсэн хөтөлбөртэй. Үндсэн хөтөлбөр нь урт хугацааны буюу 2 жилийн хөтөлбөр байх бөгөөд 2 сарын хугацаатай түвшин ахиж суралцана. Богино хугацааны хөтөлбөр нь 7-14 хоногийн хугацаатай 4 төрлөөр хичээллэж байна. Нийт 150 хүүхэд бүртгэлтэй бөгөөд анги дүүргэлт 12-16 сурагч байна.<br>**Хүрсэн түвшин:**<br>**Шинээр нээсэн сургалтын төвийн тоо-1** | 100 |
| **2.4. Хүн амын хөгжлийг хангаж, хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, ажилгүйдэл ядуурлыг бууруулна.** | | | | | | |
| 13 | Зорилтод бүлгийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, нийгмийн халамжийн бодлогыг хэрэгжүүлэн, ядуурлыг бууруулна. | 2.4.1 Өрхийн амьжиргааны түвшинг тогтоох судалгаанд үндэслэн нийгмийн халамжийн үйлчилгээг зорилтот бүлэгт хүргэнэ. | Зохион байгуулах арга хэмжээний тоо Ядуу өрхийн тоог бууруулсан байна | Амьдралын баталгаажих түвшингөөс доогуур орлоготой өрхийн судалгааг шинэчлэнэ | 2021 оны жилийн эцсийн тооллогоор амьдралын баталгаажих түвшнээс доогуур орлоготой 125 өрх бүртгэгдсэн. Үүнээс 81 өрхийг сонгон "Нэг өрх нэг ажлын байр" хөтөлбөрт хамруулан албан байгууллагуудад хуваарилан ажиллаж байна. Мөн сумын хэмжээнд хүнсний эрхийн бичигт хамрагддаг 98 өрхийг хяналтад хамруулан хөдөлмөр эрхлэх боломжтой, өрхийн ам бүл цөөн 20 өрхийг хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнээс хасах саналыг амжиргаа дэмжих зөвлөлөөр хэлэлцэн шийдвэрлэлсэн.<br>**Хүрсэн түвшин: Нийгмийн халамжид хамруулсан зорилтот өрхийн тоо- 81** | 100 |
| 14 | | 2.4.2 Өрхийн нийгэм эдийн засгийн судалгааг гаргана. | Гүйцэтгэлээр | Суурь судалгаатай болсон байна. | Аймгийн статистикийн хэлтэстэй хамтран 6 багийн 100 өрхөөр орж Өрхийн нийгэм эдийн засгийн судалгааг гаргасан.<br>**Хүрсэн түвшин:** Судалгаанд хамрагдсан өрхийн тоо- 100 | 70 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 15 | | 2.4.3 Орлого багатай өрхийн ажил эрхлэхгүй байгаа насанд хүрсэн гишүүдийг мэргэжил эзэмшүүлэх, ур чадварыг нь ахиулах сургалтанд хамруулж, хөдөлмөр эрхлэлтийг дэмжинэ. | Зохион байгуулсан сургалтын тоо | Залуучуудыг хөдөлмөр эрхлэлтэнд бэлтгэх сургалтыг 4-өөс доошгүй удаа зохион байгуулна. | "Нэг өрх нэг ажлын байр" арга хэмжээний хүрээнд сумын хэмжээнд амьдралын баталгаажих түвшнээс доогуур орлоготой 81 өрхөөс 4 өрхийг Сүмбэр сумын ЗДТГ-т хуваариласан ба өрх тус бүр дээр өрхийн хөгжлийн төлөвлөгөө гарган ажиллаж, уулзалт ярилцлага хийсэн.<br>**Хүрсэн түвшин:**<br>**Зохион байгуулсан арга хэмжээний тоо- 1**<br>**Нийгмийн халамжид хамруулсан зорилтот өрхийн тоо- 81** | 70 |
| 16 | | 2.4.4 Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээг хэрэгжүүлэн, 400 доошгүй иргэдийг байнгын, 1000 иргэдийг түр ажлын байраар байраар хангана. | Байнгын ажлын байрны тоо<br>Түр ажлын байрны тоо | Байнгын ажлын байр -100<br>Түр ажлын байр - 250 | 2022 оны хагас жилийн байдлаар хөдөлмөр халамжийн үйлчилгээний газраас байнгын ажлын байранд 35 иргэн, түр болон цагийн ажилд 120 иргэнийг зуучилж ажилласан.<br>**Хүрсэн түвшин:**<br>**Түр ажлын байранд зуучлагдсан иргэдийн тоо-120**<br>**Байнгын ажлын байранд иргэдийн тоо - 35** | 75 |
| | | 2.4.5 Аймгийн "Нэг өрх, нэг ажлын байр" хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж ажиллана. | Сумаас 82 өрхийг сонгон авна. | Хөтөлбөрийн хүрээнд сонгогдсон өрхийн иргэдийг ажлын байраар хангана | Нэг өрх нэг ажлын байр" арга хэмжээний хүрээнд сумын хэмжээнд амьдралын баталгаажих түвшнээс доогуур орлоготой 81 өрхийг сонгон авч албан байгууллагуудад хувиарлан ажлын байраар хангуулан ажилласан.<br>**Хүрсэн түвшин:**<br>Сонгогдсон өрхийн тоо- 81 | 100 |
| 17 | | 2.4.6 Жендэрийн эрх тэгш байдлыг хангах, зорилтот бүлгийн иргэдиийг дэмжих арга хэмжээг хэрэгжүүлнэ | Зохион байгуулсан сургалтын тоо<br>Хамрагдсан иргэдийн тоо | Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн талаарх сургалтыг 2 удаа зохион байгуулж 100 иргэнийг хамруулна. /Сумын ОНХС/ | Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор 2 арга хэмжээг төлөвлөсөн ба тус арга хэмжээнд 1500000 төгрөгийг зарцуулна.<br>**Хүрсэн түвшин: Зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна.** | 30 |
| 18 | | 2.4.7 Хамтарсан багийн үйл ажиллагааг дэмжиж ажиллана. | Зохион байгуулсан арга хэмжээний тоо<br>Илрүүлсэн кэйсийн тоо | Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг 2-оос доошгүй зохион | Хамтарсан багт 2022 оны хагас жилийн байдлаар 31 гэр бүлийн хүчирхийллийн тохиолдол дээр ажилласан ба нийт кэйсийн 15 буюу 48,9 хувийг шийдвэрлэсэн. Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх хяналт шалгалтын ажлыг 2 удаа, гэр бүлийн | 90 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | Хамруулсан иргэдийн тоо | байгуулж кэйс илрүүлэлтийг нэмэгдүүлнэ.Урьдчилан сэргийлэх арга хэмжээнд хүн амын 20 хувийг хамруулна. /Сумын ОНХС/ | хүчирхийллийн хохирогчид үзүүлэх тусламж үйлчилгээг 2 удаа зохион байгуулан эрсдэл бүхий 31 гэр бүлд хүрч ажилласан.<br>**Хүрсэн түвшин:**<br>**Зохион байгуулсан арга хэмжээ- 4**<br>**Нийт үүссэн кэйсийн тоо- 31** | |
| 19 | | 2.4.8 Насан туршийн боловсролын төвийн үйл ажиллагааг чанаржуулж, Японы хүүхдийг эвээх сангийн төслийн үйл ажиллагааг эрчимжүүлнэ. | Бичиг үсгийн боловсролгүй иргэдийн тоо буурсан байна. | Бичиг үсгийн боловсролгүй иргэдийн судалгааг гаргаж, иргэдийг сургалтанд хамруулсан байна. Хамруулах иргэний тоо -20 | Насан туршийн боловсролын төвд Японы хүүхдийг ивээх сангаас хэрэгжүүлж буй өсвөр залуу үеийнхэнд интерпренершипийн боловсрол олгох хөтөлбөрийн хүрээнд 20 сурагч хамрагдан амжилттай төгссөн. Төгссөн хүүхдүүдээс хэрэгжүүлэх 4 төслийг шалгаруулалтад оруулан хэлэлцүүлсэн.<br>Мөн уг сангийн тусламжтай хэрэгжиж буй өсвөр залуу үеийнхэнд интерпренершипийн боловсрол олгох төслийг ерөнхий боловсролын 1 сургуулийн 8-12 ангийн сурагчид, насан туршийн боловсролын төвийн сурагчдыг хамруулан амжилттай хэрэгжүүлж байна. Тус төслийн сургалтад 2 удаа 300 сурагч хамрагдан төгсөж байгаа бөгөөд 3 төсөл эхний шатны санхүүгийн дэмжлэг буюу 5400000 төгрөгийг авсан ба 2 дахь төгсөлтийн 15 төсөл 2 дахь шатны шалгаруулалтад оролцож байна.<br>**Хүрсэн түвшин: Сургалтанд хамруулсан иргэний тоо -20** | 100 |
| 20 | | 2.4.9 Нийгмийн салбарт чиглэсэн арга хэмжээг хэрэгжүүлнэ. | Зохион байгуулах арга хэмжээний тоо Хамрагдсан иргэдийн хувь | Биеийн тамир, спорт, соёл урлагийн 10 арга хэмжээ зохион байгуулж, нийт хүн амын 40 хувийг хамруулна. /Сумын ОНХС/ | Соёлын урлаг, спорт нийгмийн салбаруудад чиглэсэн арга хэмжээний хүрээнд 6 зорилт 21 арга хэмжээг зохион байгуулахаар төлөвлөсөн. 1.Үндэсний бөхийн холбоотой хамтран Чойрын богд хайрханы хишиг барилдаан-256 бөх<br>2.Говийн усчид клубтай хамтран Зүүн бүсийн аварга шалгаруулах усан сэлэлтийн тэмцээн-13 3.Сансар хайрхан ширээний теннсиний клубтай хамтран Сумын засаг даргын нэрэмжит Ширээний теннисний тэмцээн-60 | 90 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | 4.Бичиг үсгийн боловсролгүй иргэдийн судалгааг гаргаж насан туршийн боловсролын төвийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэн хамтран ажилласан<br>5. Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх хяналт шалгалтын ажлыг 2 удаа, гэр бүлийн хүчирхийллийн хохирогчид үзүүлэх тусламж үйлчилгээг 2 удаа зохион байгуулан эрсдэл бүхий 31 гэр бүлд хүрч ажилласан ба нийт кэйсийн 15 буюу 48,9 хувийг шийдвэрлэсэн<br>6."Боржигины оточ" эмнэлэгтэй гэрээ байгуулан Архины хэрэглээг бууруулах замаар гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, ахуйн хүрээний архидалтыг бууруулах, архины хамааралтай иргэд , түүний гэр бүлийн соён гэгээрүүлэх зорилгоор архинаас гарах сайн дурын эмчилгээнд 16 иргэнийг хамруулсан.<br>7. Хамтарсан багийн төлөвлөгөөт хурлыг 5 удаа зохион байгуулж 31 асуудлыг хэлэлцэн 100% шийдвэрлэсэн. Хамтарсан багийн гишүүдийг чадавхжуулах "Гэр бүлийн хүчирхийллийн хуулиар үүрэг хүлээсэн мэргэжилтнүүдийг чадавхжуулах сургалт"-д хамтарсан багийн 16 гишүүн хамрагдсан.<br>9.Сүмбэр сумын соёлын биет бус өвийн өвлөн уламжлагчдын анхдугаар зөвлөгөөнийг зохион байгуулан 60 иргэнийг хамруулсан.<br>10. Сүмбэр сумын хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, өрхийн эмнэлэг, сүмбэр сумын ЗДТГ, ИТХ нь гаднах хаягаа хос бичгээр бичсэн бөгөөд албан хаагчдын өрөөний хаягийг мөн хос бичгээр бичсэн. Байгууллагууд дотоод сургалтын төлөвлөгөөндөө монгол бичгийн сургалтыг тусгасан бөгөөд 300 албан хаагчийг хамруулан сургалт зохион байгуулж, албан хаагчдын түвшинг тогтоосон. | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | **Хүрсэн түвшин:**<br>**Зохион байгуулсан арга хэмжээний тоо- 10**<br>**Хамрагдсан иргэдийн тоо- 816** | |
| **Үндэсний бахархал, өв соёл** | | | | | | |
| **2.5 Үндэсний үнэт зүйл, уламжлалт өв соёлоо дээдэлж, иргэдийг соён гэгээрүүлж, соёл урлагийн байгууллагуудын үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлнэ.** | | | | | | |
| 21 | Үндэсний үнэт зүйл, уламжлалт өв соёлоо дээдэлж, иргэдийг соён гэгээрүүлж, соёл урлагийн байгууллагууды н үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлнэ | 2.5.1 Соёлын биет бус өвийг тусгасан уран бүтээлүүдийг тууривахад дэмжлэг үзүүлж, хөдөөгийн багийн иргэдэд соёлын явуулын үйлчилгээг үзүүлнэ. | Зохион байгуулах арга хэмжээний тоо Хамрагдсан иргэдийн тоо | Хөдөөгийн багийн иргэдэд 4 удаа өдөрлөг зохион байгуулж хөдөөгийн нийт иргэдийн 20 хувийг хамруулна. | Хөдөөгийн багийн иргэдэд үзүүлэх урлаг соёлын үйлчилгээг 2022 оны 06 дугаар сарын 16-ны өдөр зохион байгуулахаар төлөвлөж байна.<br>**Хүрсэн түвшин:**<br>**Зохион байгуулсан арга хэмжээний тоо-**<br>**Хамрагдсан иргэдийн тоо-** | 30 |
| 22 | | 2.5.2 Соёлын биет болон биет бус өвийг өвлөн уламжлагчдын бүртгэл судалгааг шинэчилнэ. | Хамрагдалтын хувь | 250-280 иргэний судалгаар гаргасан байна. | Соёлын биет бус өвийн өвлөн уламжлагчдын судалгааг нэгтгэн 43 иргэний судалгааг гарган, Сүмбэр сумын соёлын биет бус өвийн өвлөн уламжлагчдын анхдугаар зөвлөгөөнийг зохион байгуулан 60 иргэнийг хамруулсан.<br>**Хүрсэн түвшин:**<br>**Зохион байгуулсан арга хэмжээний тоо- 1**<br>**Хамрагдсан иргэдийн тоо- 60** | 90 |
| 23 | | 2.5.3 Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийг дэмжсэн бодлого үйл ажиллагаар хэрэгжүүлнэ. | Зохион байгуулах арга хэмжээний тоо | Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийг дэмжих 2-оос доошгүй арга хэмжээг зохион байгуулна. | Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх хяналт шалгалтын ажлыг 2 удаа, гэр бүлийн хүчирхийллийн хохирогчид үзүүлэх тусламж үйлчилгээг 2 удаа зохион байгуулан эрсдэл бүхий 31 гэр бүлд хүрч ажилласан.<br>"Боржигины оточ" эмнэлэгтэй гэрээ байгуулан Архины хэрэглээг бууруулах замаар гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, ахуйн хүрээний архидалтыг бууруулах, архины хамааралтай иргэд , түүний гэр бүлийн соён гэгээрүүлэх зорилгоор архинаас гарах сайн дурын эмчилгээнд 16 иргэнийг хамруулсан.<br>**Хүрсэн түвшин:**<br>**Зохион байгуулсан арга хэмжээний тоо-2** | 100 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 24 | | 2.5.4 Угийн бичиг хөтлөх ажлыг эрчимжүүлнэ. | Зохион байгуулсан сургалтын тоо Угийн бичиг хөтлөгч өрхийн тоо | 2-оос доошгүй сургалт зохион байгуулж, 300 өрхийг угийн бичиг хөтлүүлнэ. | Иргэдэд угийн бичгийн сургалт зохион байгуулах арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулан ажиллаж байна.<br>**Хүрсэн түвшин:**<br>**Ажил, арга хэмжээ зохион байгуулахаар төлөвлөгөө гарган ажиллаж байна.** | 30 |
| **Гурав. Эдийн засгийн бодлого** | | | | | | |
| **3.1 Санхүү эдийн засгийн нээлттэй ил тод байдлыг хангах бодлого хэрэгжүүлнэ.** | | | | | | |
| 25 | Төсвийн сахилга батыг сайжруулж зардлыг багасган, хэмнэлтийг эрхэмлэнэ. | 3.1.1 Төсөв, санхүүгийн нэгдсэн цахим систем нэвтрүүлж, төрийн үйлчилгээг шуурхай болгож, төсвийн урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг ил тод, хэмнэлттэй зарцуулна | Зөрчил гараагүй байна. | Төсвийн үр ашиггүй зардлыг хэмнэж, зарцуулалтанд тавих хяналтыг чангатгана. | Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зориулалтын дагуу зарцуулах, орлогын төлөвлөгөөний биелэлтийг хангах талаар анхааран ажиллаж байна. Үүссэн өр авлаганд хагас жилийн тодотголоор зохицуулалт хийнэ. Засаг даргын тамгын газар авлага 265,0, төг, өглөг 2733,7 мянган төгрөгний тогтмол зардлын өртэй байна.<br>Төрийн албаны цалингийн системд сумын харьяа 3 сургууль, 4 цэцэрлэг, Засаг даргын тамгын газар, Иргэдийн төлөөлөгчдын хурал, ӨЭМТөв, Тохижилт сүмбэр зэрэг аж ахуй нэгж байгууллагууд бүрэн хамрагдсан. Шилэн дансны цахим системд 44 мэдээлэл байршуулсан.<br>**Хүрсэн түвшин:**<br>**Хяналт шалгалтын тоо -0**<br>**Илрэрсэн зөрчил-0**<br>**Орлогын биелэлт- 96.5%** | 60 |
| 26 | | 3.1.2 Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хийгдэх ажлыг иргэдэд бүх шатанд ил тод, нээлттэй болгож, зарцуулалтын үр дүнг дээшлүүлнэ | Сумын нийт өрхийн 80%-аас санал авч иргэдэд жилд 2 удаа тайлагнасан байна. | Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлнэ. | ОНХС-ын саналыг авахдаа Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журмын дагуу иргэдээс саналын хуудсаар болон мэдээлэл технологийн аргаар 1110 хүний саналыг авч тусгасан<br>**Хүрсэн түвшин:**<br>**Санал өгсөн иргэдийн тоо-1110** | 100 |
| 27 | | 3.1.3 Тендер шалгаруулалтын үйл ажиллагааг бүрэн цахимжуулж, үр дүнг сайжруулна. | Зөрчил гараагүй байна. | Худалдан авах ажиллагааг 100% цахим хэлбэрээр зохион зөрчилгүй байгуулна. | 2022 оны Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд нийт 8 хөрөнгө оруулалт, их засвар, бараа тоног төхөөрөмж худалдан авах цахим тендер шалгаруулалтыг төлөвлөж төрийн худалдан авах ажиллагааны цахим системд баталгаажуулсан. Төлөвлөлтийн хүрээнд | 70 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 28 | | | | | хөрөнгө оруулалтын 7 ажлыг төрийн худалдан авах ажиллагааны цахим системээр зохион байгуулж урилга үр дүнг цахимаар зарлан мэдээлж байна.<br>**Хүрсэн түвшин:**<br>**Төлөвлөгөөний хэрэгжилт 70 хувь** | |
| **Дөрөв: Хөдөө аж ахуйн бодлого** | | | | | | |
| **4.1 Малын чанар, ашиг шимийг сайжруулж, малын тоог чанарт шилжүүлж малын генийн санг хамгаалах, биотехнологийн ололтыг нэвтрүүлэх, эрчимжсэн мал аж ахуйн салбарын хөгжлийг дэмжинэ.** | | | | | | |
| 28 | Бэлчээрийн мал аж ахуйг эрсдлээс хамгаалж, үүлдэр угсааг сайжруулж ашиг шимийг дээшлүүлнэ | 4.1.1 Уламжлалт мал аж ахуйд биотехнологийн ололтыг нэвтрүүлэх, нэг малаас авах ашиг шимийн гарцыг нэмэгдүүлнэ. | Биотехнологий нолоптыг нэвтрүүлэх. Нэг малаас авах ашиг шимийн гарцын судалгаанд дүгнэлт хийж арга хэмжээг төлөвлөсөн байна. | Малчид иргэдийн захиалгаар Биотехнологийн дэвшилтэт аргыг өргөн хэрэглэж үр дүнд хүрсэн байна.<br><br>\ОНХСан-800,0\ | Уламжлалт мал аж ахуйд биотехнологийн ололтыг нэвтрүүлэх, нэг малаас авах ашиг шимийн гарцыг нэмэгдүүлэх зорилгоор зохиомол хээлтүүлгийг 10 сард хийхээр төлөвлөсөн байна.<br>Нийт 92 малчин өрхийн 26191 ямаанд хэмжилт хийж бүдүүн ухна 0.546 гр, өсвөр ухна 0.475 гр, эр ямаа 0.626 гр, эм ямаа 0,482 гр, өсвөр 343 гр, сумын дунгээр ямааны ноолуурын гарцын дундаж 0,495 гр байна<br>**Хүрсэн түвшин: 10 сард зохион байгуулахаар төлөвлөсөн.** | 65 |
| 29 | | 4.1.2 Бүс нутагт тохирсон мал аж ахуйг бодлогоор хөгжүүлнэ. | Үхэр, хонийг махны чиглэлээр, ямааг ноолуурын чиглэлээр үржүүлэх бодлогыг хэрэгжүүлнэ | Сайн чанарын хээлтүүлэгчийг чиглэлтэй сонгон үржүүлэх, зөв зохистой ашиглах ажлыг зохион байгуулсан байна. Бог малын хээлтүүлэгчийг МҮТАҮН-н мэдэлд 100% ялгасан байна.<br>\ОНХСан-600,0\ | Сүмбэр үүлдрийн хонины тоо 2022 оны эхэнд цэвэр үүлдэр нь 1086, эрлийз 128 толгойд хүрсэн байна. Хуц 59, хээлтэгч 760 байна<br>Төлөвлөгөөний дагуу нийт 35 бух ялган тэмдэгжүүлэхээс 5 сарын 18-ны байдлаар 12 бух ялган тэмдэгжүүлсэн байна.<br>**Хүрсэн түвшин: Төлөвлөгөөний хэрэгжилт- 100**<br>**Цөм сүргийн тоо-1196**<br>**Нийт ялгасан бог малын хээлтүүлэгчийн хувь-59**<br>**Ялгаж тэмдэгжүүлсэн бухны эзлэх хувь-34.2** | 80 |
| 30 | | 4.1.3 Мал амьтаны генетик нөөцийг бүртгэх, төлөв байдлыг тодорхойлох хадгалах, хамгаалах, тогтвортой, зохистой ашиглана. | Мал сүргийг ангилан баталгаажуулах, эзэмжүүлэн бүртгэлжүүлэх удам зүйн үнэлгээний | Ангилалт баталгаажуулалт анд хамрагдаж цөм сүрэгт бүртгэгдсэн мал сүргийг удам зүйн үнэлгээ хийж, | Зоо бонитор мөнх" МҮТАҮНэгж /мал үржлийн технологит ажил үйлчилгээний нэгж/-тэй гэрээ байгуулан мал аж ахуйн технологит ажлыг цаг хугацаанд нь зохион байгуулж хяналт тавин ажиллаж байна.<br>5 сарын 18-ны байдлаар бог мал хээлтүүлэгчийг 4 МҮНэгжийн 9 малчинд нийт | 90 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | программ болон цахим санд бүртгэх ажлыг зохион байгуулна | удам зүйн программ болон цахим санд 100 хувь бүртгэсэн байна. \ОНХСан -800,0\ | 659 хуц, 351 ухна нийт 1010 хээлтүүлэгч малыг ялган суурилуулаад байна Энэ нь ялгавал зохих нийт хээлтүүлэгч малын 54,5 хувийг эзлээд байна. **Хүрсэн түвшин:** **Технологийн мөрдөлтөд тавих хяналтын тоо-1** **Ялган суурилсан хээлтүүлэгч- 54.5** **Мэргэжлийн байгууллагын хяналтад авсан хээлтүүлэгч- 1010 буюу 100%** **Баталгаажсан цөм сүргээс бойжуулсан үржлийн мал- 10 сард зохион байгуулахаар төлөвлөсөн.** | |
| 31 | | 4.1.4 Сумын хэмжээнд "Мал хамгаалах", "Малжуулах" арга хэмжээг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ | Малчин өрхийн тоо Малын тоо | 600 малыг 20 малчин өрхөд өгч малжуулна | Дэлхийн зөн олон улсын байгууллага Бор-Өндөр 1 орон нутгийн хөтөлбөртэй хамтран аюулгүй хишиг гудамж, малжуулах төслийг хэрэгжүүлж, малжуулах төслийн хүрээнд амьдралын баталгаажих түвшнээс доогуур орлоготой мал маллах сонирхолтой 15 өрхийг тус бүр 20 хургатай хониор малжуулан ажиллалаа. **Хүрсэн түвшин:** **Малчин өрхийн тоо-15** **Малын тоо- 600** | 90 |
| 32 | | 4.1.5 ХАА-н салбарын өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангуулах, ган зудын эрсдлийг бууруулах арга хэмжээг төлөвлөгөөтэй үе шаттай хэрэгжүүлэх | ХХААСайдын 2016.05.10-ны өдрийн А/71 дугаар тушаалаар баталсан "Мал өвөлжилтийн бэлтгэл хангах, шалгах, дүгнэх заавар"-ыг баримтлана. | Төлөвлөгөө боловсруулан батлуулж хэрэгжилтийг хангаж ажилласан байна. Өвөлжилтийн бэлтгэл хангалт 85%-аас доошгүй. | Мал аж ахуйг байгаль, цаг уурын эрсдлээс хамгаалан, бэлэн байдлыг хангаж, өвс тэжээлийн нөөц бүрдүүлэх ажлыг 9-10 сард зохион байгуулахаар төлөвлөсөн. **Хүрсэн түвшин: 10 сард зохион байгуулахаар төлөвлөсөн.** | **30** |
| 33 | | 4.1.6 Эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлнэ. | Үхэр,хонийг махны, ямааг ноолуурын чиглэлээр үржүүлэх, гахай,тахиа үржүүлэгчдийг | Махны чиглэлийн үхэр, хонийг дагнан үржүүлэх, гахай, тахиаг технологийн дагуу стандартад нийцүүлэн үр ашигтай | Сумын нийт ямааны 20.6 хувийг хамруулан ноолуурын микроныг хэмжилтийг хийсэн. Нийт 92 малчин өрхийн 26191 ямаанд хэмжилт хийж бүдүүн ухна 0.546 гр, өсвөр ухна 0.475 гр, эр ямаа 0.626 гр, эм ямаа 0,482 гр, өсвөр 343 гр, сумын дүнгээр ямааны ноолуурын гарцын дундаж 0,495 гр байна. | 70 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | бодлогоор дэмжинэ. | үржүүлэх арга зүйг иргэдэд олгох ажлыг зохион байгуулсан байна. | Энэ онд 12 өрх, 1 ААНБ 153 гахай, 7 өрх 88 тахиа, 1 өрх 1 нугас үржүүлж байна. Эрчимжсэн аж ахуйн бүсэд 5 өрх, суурьшлын бүсээс гадна 6 өрх байна. Одоогийн байдлаар 1,83 тн гахайн мах үйлдвэрлэсэн нь өмнөх оны энэ үеэс 0,63 тн махаар нэмэгдсэн.<br>**Хүрсэн түвшин:** | |
| 34 | | 4.1.7 Мал амьтны эрүүл мэндийг хамгаалан, мал, амьтны гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлагыг хангаж, нийтийн эрүүл мэндийг хамгаална | Халдварт өвчнөөс эмчлэн сэргийлэх биотарилгад хамруулж, дархлаажуулах Малаас гаралтай хүнс түүхий эдийн чанарыг сайжруулах,зөв хөн шаардлага хангасан түүхий эд бүтээгдэхүүний г хүнсний хэрэгцээнд нийлүүлэх, | Төлөвлөгөөт малыг 80 хувь био тарилга, лаборторийн шинжилгээнд хамруулах | Мал, амьтны халдварт, гоц халдварт, шимэгчлэх өвчнөөс урьдчилан сэргийлэх тэмцэх арга хэмжээг 3- 5 дугаар сард зохион байгуулан ужиг халдварт өвчнөөс сэргийлэх тарилгыг 62,6 мянган толгой малд хийхээс 48.8 толгой малд хийж 77%-тай, гоц халдварт шулхий өвчнөөс сэргийлэх тарилгыг 12191 үхэр, 109 гахайд хийхээс 10662 үхэр, 144 гахайд хийж 88, хувь, шимэгчлэх өвчнөөс сэргийлэх тарилгыг 398.7 мянган толгой малд хийхээс 84.6 толгой малд хийж 21.2 хувьтай байна. Зооноз өвчнөөс сэргийлэх тарилгыг 8 дугаар сард хийхээр төлөвлөөд байна.<br>**Хүрсэн түвшин: Ужиг халдварт өвчнөөс сэргийлэх тарилгад хамруулсан малын тоо- 48.8 мянга**<br>**Гоц халдварт шулхий өвчнөөс сэргийлэх тарилгад хамруулсан малын тоо- 10806**<br>**Шимэгчлэх өвчнөөс сэргийлэх тарилгад хамруулсан малын тоо- 84.6** | 80 |
| **4.2 Хоршоо, ахуй үйлчилгээ эрхлэгчдийг чадавхижуулж, ажлын байрыг нэмэгдүүлэх, орон нутгийн брэндийг хөгжүүлэн, бичил үйлдвэрлэлийг дэмжиж ажиллана.** | | | | | | |
| 35 | Хоршоо, ахуй үйлчилгээ эрхлэгчдийг чадавхижуулж ажлын байрыг нэмэгдүүлэх, | 4.2.1 Хоршоо хөгжүүлэх сангийн үйл ажиллагааг хуулийн хүрээнд чанартай зохион байгуулна. | Зээлд хамрагдсан хоршооны тоо | - | Сумын ИТХ-ийн 2022.03.17-ны өдрийн 08 дугаар тогтоолоор Хоршоо хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, тэргүүлэх салбар чиглэлийг баталсан. Тэргүүлэх чиглэлтэй уялдуулан хоршоо хөгжүүлэх сангийн төсөл сонгон шалгаруулах зарыг | 100 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | орон нутгийн брэндийг хөгжүүлэн, бичил үйлдвэрлэлийг дэмжиж ажиллана. | | | | нийтэд 30 хоногийн хугацаатай зарлаж нийт 15 төслөөс хоршооны 3 төсөл, жижиг дунд үйлдвэр эрхлэгчийн 12 төсөл ирсэн. Ирүүлсэн 15 төсөлд:<br>1-р шатны баримт бичгийн иж бүрдлийн шалгалтаар - 13<br>2-р шатны нарийвчилсан үнэлгээгээр – 1 нийт 14 төсөл хасагдаж<br>3-р шатанд "Жавхлант Аривжих ХХК"-ны "Барилгын материалын тусах төмөр хийц бүтэц, бусад төмөр хийцийн "Аривжих" үйлдвэр төсөл тэнцэж сумын Засаг даргын захирамжаар 70,0 сая төгрөгийн санхүүжилтийг 2022.05.20-нд олгосон.<br>**Хүрсэн түвшин:**<br>**Ирсэн төслийн тоо 15**<br>**Шалгарсан төслийн тоо 1**<br>**Олгох мөнгөн дүн- 70,0 сая** | |
| 36 | | 4.2.2 Суманд үйл ажиллагаа явуулж байгаа бүх төрлийн хоршооны үйл ажиллагааг дэмжиж хамтран ажиллана. | Хоршооны байртай болно. | Хоршооны үйл ажиллагаа өргөжиж, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангагдана. | Хоршооны хууль шинэчлэн батлагдсантай холбогдуулан хоршооны гишүүдэд эрх зүйн сургалтыг 2 удаа зохион байгуулж давхардсан тоогоор 31 гишүүн оролцов. Хоршоологчидтой уулзалт хэлэлцүүлэг 1 удаа 8 иргэн, Мал аж ахуйн гаралтай түүхий эд бэлтгэх технологийн сургалтыг 1 удаа зохион байгуулж сургалтад 16 хоршоог хамруулсан.<br>Тайлант хугацаанд Түүхий эдэд анхан шатны боловсруулалт хийх, мал аж ахуйн чиглэлээр 1 хоршоо байгуулагдсан.<br>**Хүрсэн түвшин:**<br>**Зохион байгуулсан сургалт, нөлөөллийн арга хэмжээний тоо 4**<br>**Хамрагдсан гишүүдийн тоо /давхардсан тоогоор/ - 55**<br>**Үзэсгэлэн худалдаа зохион байгуулах хугацаа болоогүй** | 70 |
| **4.3 Хүнсний үйлдвэрлэлийг дэмжиж, хүнсний аюулгүй байдлыг хангаж ажиллана.** | | | | | | |
| 37 | Хүнсний үйлдвэр, мал аж ахуй, газар | 4.3.1 "Эрүүл хүнс - Эрүүл Монгол хүн " арга хэмжээг хэрэгжүүлнэ. | Тухайн жилийн төлөвлөгөөний | "Эрүүл хүнс, эрүүл Монгол хүн" арга | "Эрүүл хүнс-Эрүүл Монгол хүн" хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө гаргаж, батлаад ажиллаж байна. Нийтийн хүнсний хэрэгцээнд | 50 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | тариалан эрхлэгчдэд эрүүл ахуйн болон үйлдвэрлэлийн зохистой дадал нэвтрүүлж, хүн амаа аюулгүй эрүүл хүнсээр хангах бодлого баримтлана | | хэрэгжилт - 100% | хэмжээний биелэлт хангагдана. | нийлүүлэгдэж байгаа мал, амьтны гаралтай мах, сүүний 186 сорц авч шинжилгээнд хамруулсан. Ил задгай худалдаа хийлгэхгүй байх талаар 134 ширхэг гарын авлага тарааж заавар зөвлөмж өгч хяналт тавьж ажиллаж байна. | |
| 38 | | 4.3.2 Суманд мал нядалгааны газар байгуулна. | Гүйцэтгэлээр | Мал нядалгааны цех -1 | Мал нядалгааны цехүүдийн үйл ажиллагаанд нь стандартыг мөрдүүлэх зорилгоор 1 удаагийн хяналт шалгалтыг зохион байгуулан заавар зөвлөмж өгч ажилласан ба аймгийн Мэргэжлийн хяналтын газартай хамтран махыг тогтмол сорьц, шинжилгээнд хамруулж байна.<br>**Хүрсэн түвшин:**<br>**Сурталчилгаа, мэдээлэл-1**<br>**Зээлийн дэмжлэг үзүүлсэн иргэн, аж ахуйн нэгж тоо-0** | 50 |
| 39 | | 4.3.3 Хүнсний аюулгүй байдлыг хангаж ажиллана. | Зах зээлд борлуулж буй малын гаралтай түүхий эдэд хяналт тавьж эрүүл ахуйн шаардлагад хяналт тавьж ажиллана. | Эрүүл ахуйн шаардлага хангасан бүтээгдэхүүн хэрэглэгчдэд хүрнэ. \Хийх хяналт шалгалтын ажлын тоо-4\ | Багийн засаг дарга нартай хамтран 3 удаагийн хяналт шалгалт хийж худалдаа үйлчилгээний 49 газарт халдвар хамгааллын дэглэм сахиулах, ил задгай худалдаа хийлгэхгүй байх талаар 134 ширхэг гарын авлага тарааж заавар зөвлөмж өгч хяналт тавьж ажилласан. Нийтийн хүнсний хэрэгцээнд нийлүүлэгдэж байгаа мал, амьтны гаралтай мах, сүүний 186 сорц авч шинжилгээнд хамруулсан.<br>**Хүрсэн түвшин:** Хяналт шалгалтын ажлын тоо-3 | |
| **Бэлчээр, газар тариалан** | | | | | | |
| **4.4.Бэлчээрийн менежментийн тогтвортой байдлыг хангах, тариалангийн үйлдвэрлэлийн нөөц ашиглалтыг сайжруулж, төмс, хүнсний ногооны хангамжийн хувь хэмжээг нэмэгдүүлнэ.** | | | | | | |
| 40 | Газар тариалангийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ. | 4.4.1 Хадлан бэлтгэх, хүлэмжийн аж ахуй, усалгаатай газар тариалан эрхлэгчдийг бодлогоор дэмжинэ. | Шинээр 120м2 талбай бүхий зуны хүлэмж ашиглалтанд орсон байна. | Хүлэмжийн аж ахуйн тариалалт нэмэгдсэн байна. | Чойр нарлаг хүлэмж хоршоо нь аймгийн ЖДҮДСангаас 2020 онд өвлийн хүлэмж барих санхүүжилт авч хүлэмжийн барилгын ажил 30%-тай, Чойрын богд хоршоо нь өөрсдийн хувь нийлүүлсэн хөрөнгөөр 15х30 харьцаатай өвлийн хүлэмж барих барилгын ажлыг эхлүүлсэн. Гүйцэтгэл 70%-тай явагдаж байна. | 100 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | | Газар тариалангийн үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжих зорилгоор 6x20, ба 4x8 харьцаатай хүлэмжийг хөнгөлөлттэй үнээр олгон сонгон шалгаруулалтанд 2 аж ахуйн нэгж, 10 иргэн материалаа хүргүүлээд байна. 5 сарын 18-ны байдлаар 4 иргэн 488м² талбайтай 7 хүлэмжид тариалалт хийхээр бэлдээд байна.<br>**Хүрсэн түвшин: Зохион байгуулсан арга хэмжээ- 1**<br>**Өвлийн хүлэмжний тоо 1**<br>**Нийллэг хүлэмжний тоо 7 буюу 29 хувиар нэмэгдсэн.** | |
| 41 | | 4.4.2 Өрх, иргэдийг төмс, хүнсний ногоо, жимс жимсгэнэ тариалж өөрсдийн хэрэгцээг хангах санаачлагыг дэмжинэ | Эргэлтийн талбайг 35 га-д хүргэх нэгжийн ургацыг 65 цн/га-аас доошгүй байлгана. | Газар тариалангийн үйлдвэрлэл өмнөх оноос өсөж, нэгжээс авах ургацын хэмжээ нэмэгдэнэ. | 5 сарын 18-ны байдлаар төмс-7 га, хүнсний ногоо-5,5 га нийт 12,5 га тариалалт хийгээд байна. Энэ нь өмнөх оны энэ үетэй харьцуулахад 7,5 га талбайгаар нэмэгдсэн үзүүлэлттэй байна . Мөн тэвш болон хаялага нуурын тариалангийн бүсэд нийт 11 га талбайд тэжээлийн ургамал тариалахаар газраа бэлдсэн.<br>**Хүрсэн түвшин: Талбайн хэмжээ- 23.5 га** | 100 |
| 42 | | 4.4.3 Сумын хэмжээнд зоорь, агуулах шинээр бий болгоно. | Шинээр байгуулагдах агуулах зоорийн тоо-1 | Зоорь агуулахаас ээх зээлд нийлүүлэх бүтээгдэхүүний хэмжээ мах 150 тн , 80 тн төмс, хүнсний ногоо | Энэ оны эхний хагас жилийн байдлаар Зээлийн дэмжлэг үзүүлсэн иргэн, аж ахуйн нэгж байхгүй ба шинээр нэмэгдсэн зоорь агуулах байхгүй.<br>**Хүрсэн түвшин:**<br>**Шинээр нэмэгдсэн зоорь, агуулахын тоо-0**<br>**Зоорь, агуулах барих чиглэлээр зээлийн дэмжлэг авсан аж ахуй нэгжийн тоо-0** | - |
| 43 | | 4.4.4 Төмс, хүнсний ногооны хангамжийн хувь хэмжээг нэмэгдүүлнэ. | Эргэлтийн талбайн хэмжээ 30,5 га талбайн ашиглалтын хувь 42 | Эргэлтийн талбайн хэмжээ 35, талбайн ашиглалтын хувь -45, төмс, хүнсний ногооны хангамжийн хувь 20 | 5 сарын 18-ны байдлаар төмс-7 га, хүнсний ногоо-5,5 га нийт 12,5 га тариалалт хийгээд байна. Энэ нь өмнөх оны энэ үетэй харьцуулахад 7,5 га талбайгаар нэмэгдсэн үзүүлэлттэй байна . Мөн тэвш болон хаялага нуурын тариалангийн бүсэд нийт 11 га талбайд тэжээлийн ургамал тариалахаар газраа бэлдсэн.<br>**Хүрсэн түвшин: Талбайн хэмжээ- 23.5 га** | 90 |
| 44 | | 4.4.5 Сумын бэлчээрийн менежментийн төлөвлөгөөг боловсруулна. | | Тухайн жилийн төлөвлөгөөний хэрэгжилт -100% | Бэлчээрийн менежментийг сайжруулах зорилгоор малчдын 10 бүлэгт ногоон тэжээл тариалах чиглэлээр сургалт зохион | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | Гүйцэтгэлээр | | байгуулж, арга зүйн зөвлөгөө өгч үрийн дэмжлэг үзүүлэхээр 400 кг үрийн захиалга өгөөд байна.<br>**Хүрсэн түвшин:**<br>**Гүйцэтгэлийн хувь- 50** | 50 |
| 45 | | 4.4.6 Бэлчээрийн хортон мэргэчидтэй тэмцэнэ. | 10000 га талбайд бэлчээрийн хортон мэргэчидтэй тэмцэнэ. | Бэлчээрийн гарц сайжирна. Ургамалын төрөл олширно. | Сумын хэмжээнд 422 өрхийн 28 малчны бүлэг байгуулагдсан. Хөнөөлт мэрэгчдийн тархалтын судалгааг 4-р багийн хавиргын ухаа, баянхошуу, эхэнсүвээ, цовхон гашуун зэрэг газрын 30 га талбайд зохион байгуулсан. Үүнээс 15,0 га талбайд малчдын бүлгийн оролцоотой хортон мэрэгчтэй тэмцэх ажлыг зохион байгуулахаар төлөвлөөд байна.<br>**Тандалт судалгаа хийсэн талбайн хэмжээ 30,0га**<br>**Тэмцэх талбайн хэмжээ 15га** | 50 |
| 46 | | 4.4.7 Сумын нийт бэлчээрийн даацыг тодорхойлж дүгнэлт гаргана. | Хавар намар 2 удаа | Малын тоо толгой багтаамжыг тооцон бэлчээрийн ашиглалт хамгаалалтыг сайжруулах | Сумын нийт бэлчээрийн даацыг тодорхойлж дүгнэлт гаргах ажлыг 8 сард зохион байгуулахаар төлөвлөсөн.<br>**Хүрсэн түвшин: Зохион байгуулахаар төлөвлөсөн** | 30 |
| **Аялал жуулчлал** | | | | | | |
| **4.5 Орон нутгийн онцлог, нутгийн иргэдэд түшиглэсэн тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлнэ.** | | | | | | |
| 47 | Аялал жуулчлалын салбарыг хөгжүүлж, менежментийг боловсронгуй болгож, материаллаг баазыг бэхжүүлнэ | 4.5.1 Жуулчны бааз байгуулах санал санаачлагыг дэмжиж ажиллана. | Гүйцэтгэлээр | Жуулчны бааз байгуулна | Хоршоо хөгжүүлэх сангийн төсөл сонгон шалгаруулах тэргүүлэх чиглэлд аялал жуулчлал, жуулчны баазын байгуулах чиглэлд зээлийн дэмжлэг үзүүлэхээр тусгагдсан.<br>**Хүрсэн түвшин:**<br>**Үйл ажиллагаа явуулж буй жуулчны баазын тоо-1**<br>**Зээл хүссэн төсөл ирээгүй.** | 30 |
| **4.6 Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын салбарыг орон нутагт хөгжүүлж, иргэдийн орон сууцны хангамжийг нэмэгдүүлнэ.** | | | | | | |
| 48 | Газар зохион байгуулалтын менежментийг сайжруулж, | 4.6.1 Сумын газар зохион байгуулалтын менежментийг сайжруулна. | Тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөний | | Сүмбэр сумын 2022 оны "Газар зохион байгуулалтын төлөвлөгөө"-ний дагуу Сүмбэр сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 08 дугаар | 70 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | газар олголтыг эрчимжүүлнэ | | хэрэгжилт-100% | | тогтоол, 2022 оны 03 дугаар сарын 17-ны өдрийн 17 дугаар тогтоолын нэмэлт өөрчлөлтөнд үндэслэн 10 байршлын 13,5 га талбайн дуудлага худалдааг зарласан. Мөн газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах эрхийн гэрчилгээний дуудлага худалдааг зохион байгуулан холбогдох зар мэдээг "Зууны мэдээ" сонин болон www.mle.mn цахим сайтанд байршуулан ажиллаж байна. **Хүрсэн түвшин: Зохион байгуулсан арга хэмжээний тоо-1** | |
| 49 | | 4.6.2 Газар зүйн нэрийг тодотгох ажлыг зохион байгуулна. | Газрын хамрагдалтын хувь . | | 2022 онд газар зүйн нэрийг тодотгох ажлыг 3-р улиралд хийхээр төлөвлөж сумын орон нутгийн хөгжил сангаас 4.8 сая төгрөгийг батлуулсан. Мөн аймгийн ГХБХБГ-аас газарзүйн нэрийн тодруулалтын ажил хийхтэй холбогдуулан мэргэжил арга зүйн зөвлөгөө авч, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын дарга болон сумын засаг дарга нарын газар зүйн нэрийн тодруулалт, мэдээллийн сан бүрдүүлэх ажлын даалгаварыг боловсруулсан. Уг гэрээний төслийг батлуулахаар холбогдох байгууллагад хүргүүлээд байна. **Хүрсэн түвшин: Боловсруулалтын шатанд** | 30 |
| 50 | | 4.6.3 Иргэд, малчдын эзэмшлийн өвөлжөө, хаваржааны газрын давхардлыг арилгаж, газар эзэмших эрхийн гэрээ, гэрчилгээнд хуулийн дагуу хяналт тавьж ажиллана. | Гүйцэтгэлээр | | 2022 оны 05 дугаар сарын 18-ны өдрийн байдлаар хаягийн мэдээллийн санд бүртгэлтэй нийт 7289 нэгж талбар, 361 барилгын орц, гарцыг тодорхойлон, Газрын мониторингийн хянан баталгааны системээр дамжуулан Газрын захиалгат хянан баталгааг цахимаар тогтмол хийж гүйцэтгэж байна. **Хүрсэн түвшин: Гүйцэтгэлийн хувь- 70** | 70 |
| **ТАВ .ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО** | | | | | | |
| **5.1 Мэдээллийн аюулгүй байдлыг хангасан цахим орчныг бүрдүүлэн, ил тод байдлыг хангаж, иргэд, олон нийтэд мэдээ, мэдээлэл, төрийн үйлчилгээг шуурхай, хариуцлагатай, хүртээмжтэй хүргэх орчин нөхцлийг бүрдүүлнэ.** | | | | | | |
| 51 | Иргэд, олон нийтэд мэдээ, мэдээлэл, | 5.1.1 Сум, багийн Засаг дарга, Засаг даргын Тамгын газрын | Багийн ИНХ-ын үйл ажиллагаа тогтмолжино | Төрийн үйлчилгээний ил тод байдлыг | 04 дүгээр сарын 06-08-ны өдрүүдэд хөдөөгийн багийн иргэдэд сумын ЗДТГ-аас хийж байгаа ажил арга хэмжээг "Богцтой | **80** |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 52 | төрийн үйлчилгээг шуурхай, хариуцлагатай, хүртээмжтэй хүргэх орчин нөхцөлийг бүрдүүлнэ. | ажлын мэдээллийг хуулийн хүрээнд иргэдэд мэдээлнэ. | | хангаан, төрийн үйлчилгээг шуурхай , хүртээмжтэй чанартай хүргэнэ. | мэдээлэл" хэлбэрээр бэлтгэн хүргэсэн.1,2 дугаар баг өдөрлөгөө зохион байгуулж хийж байгаа ажлынхаа талаар мэдээлэл хүргэсэн. Аймгийн Засаг даргын мэдээллийг сумын хэмжээнд 3 удаа зохион байгуулсан.<br>06 дугаар сарын 16-ны өдөр хөдөөгийн багийн иргэд залуучуудыг хамруулсан "Хөдөөгийн баясгалан" өдөрлөгийг зохион байгуулж 250 гаруй хүн хамрагдсан. Өдөрлөгөөр орон нутгийн төрийн байгууллагууд иргэдэд мэдээлэл хүргэсэн. | |
| 52 | | 5.1.2 E-mongolia системээр төрийн үйлчилгээ авах орчин, нөхцлийг бүрдүүлж, хөдөөгийн багуудыг интернэт сүлжээнд холбоно. | Зохион байгуулсан арга хэмжээний тоо | | Аймгийн ЗДТГ-аас зохион байгуулсан E-mongolia системээр төрийн үйлчилгээ авах талаар иргэдэд зөвлөгөө, мэдээллээр хангах өдөрлөгт сумын 96 иргэнийг хамруулан мэдээ мэдээлэл өгч ажилласан. E-mongolia системээр 522 иргэн үйлчлүүлж, 28 төрлийн лавлагааг 392 иргэнд олгосон. Олгосон лавлагааны 66,5 хувь нь оршин суугаа хаягын лавлагаа эзэлж байна. Цахимаар ирсэн 3 хүсэлтийг хүлээн авч хугацаанд нь бүрэн шийдвэрлэсэн. 6-р багт жи мобиалын 4 жи интернет сүлжээ оруулах ажил гүйцэтгэлийн шатандаа байна.<br>**Хүрсэн түвшин:**<br>**e-mongolia системд шинээр орсон үйлчилгээний тоо - 1**<br>**Олгосон лавлагааны төрөл - 28**<br>**Лавлагааны тоо – 522**<br>**Зохион байгуулсан арга хэмжээ-4** | 90 |
| 53 | | 5.1.3 Иргэдэд хүргэх цахим мэдээллийг чанаржуулж, тэдний чадваржуулна. | Гүйцэтгэлээр | Хуулийн хэрэгжилт хангагдана | Байгууллагын цахим хуудсанд 463 мэдээлэл оруулахад 2150 хандалттай, Засгийн газрын 2021 оны 374 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан "Мэдээллийн ил тод байдлын шалгуур үзүүлэлт"-ийн дагуу байгууллагын цахим хуудаст баяжилт хийж байна. Сүмбэрийн мэдээ, Сүмбэр сумын засаг даргын Тамгын газар фейсбүүк хуудаст 1002 мэдээлэл оруулсан байна. Хандалтын хүмүүсийн эрэгтэй 42,1 хувь, эмэгтэй 57,9 хувийг эзэлж байна. Байгууллагын цахим хуудасны баяжилт бүрэн дуусаагүй гүйцэтгэл 70 хувьтай хийгдэж байна. Цахим хуудасны | 70 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | засвар мэдээллийн баяжилт бүрэн хийгдэж дуусаагүй байгаа учраас хандалтын тоо зорилтот түвшиндээ бүрэн хүрээгүй байна.<br>**Хүрсэн түвшин:**<br>**Төлөвлөгөөний хэрэгжитийн хувь-70** | |
| 54 | | 5.1.4 Байгууллагын архивын хадгалалт хамгаалалтын нөхцлийг сайжруулж, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангана. | Шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангагдсан байна. | Хуулийн хэрэгжилт хангагдана. | Байгууллагын архивын баримт бичгийг цэгцлэх хүрээнд 3-р багийн иргэн Батчимэгтэй гэрээ байгуулж байнга хадгалах хадгаламжийн нэгжийн 1996-2021 оны 244 баримт, 70 жил хадгалах 1974-2021 оны 86 баримтыг стандартыг дагуу цэгцэлж нийт 330 баримтыг аймгийн Төрийн архивт шилжүүлсэн. Устгах 1980-2021 оны 260 баримтыг аймгийн баримт бичиг нягтлан шалгах комиссын хурлаар хэлэлцүүлэхээр шилжүүлсэн. Байгууллагын захирамж тушаал ирсэн бичиг, явсан бичгийн хавтасыг монгол бичгээр нүүрлэсэн. Байгууллагын дотоод сургалтыг 2 удаа зохион байгуулж 32 албан хаагч хамрагдсан.<br>**Хүрсэн түвшин:**<br>**Зохион байгуулсан арга хэмжээний тоо 2**<br>**Хамрагдсан албан хаагчдын тоо 32**<br>**Архиын ажлын гүйцэтгэл – 100%** | 100 |
| **Мэргэшсэн хариуцлагатай төрийн алба** | | | | | | |
| **5.2. Нутгийн захиргааны байгууллагуудыг чадавхжуулж, төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулж, төрийн албан хаагчдын ёс зүй, хариуцлагыг дээшлүүлнэ.** | | | | | | |
| 55 | Төрийн албан хаагчдын харилцаа, хандлага, ёс зүйг сайжруулж, хариуцлагыг нэмэгдүүлнэ | 5.2.1 Төрийн албыг мэргэшсэн, тогтвортой үйл ажиллагаа явуулах, төрийн албаны залгамж чанарыг хангах, төрийн албан хаагчдын манлайлал, мэргэжил, ур чадварыг дээшлүүлэх төрийн албанд шатлан дэвших нөхцлийг бүрдүүлэх зорилгоор Төрийн албан хаагчдын мэдлэг, чадварыг дээшлүүлэх, ажиллах нөхцөл, нийгмийн баталгаар хангах арга хэмжээг хэрэгжүүлнэ. | Нийгмийн баталгаар хангах төлөвлөгөөний хэрэгжилт-100% | Төрийн албыг мэргэшсэн, чадварлаг, шударга, хариуцлагатай, албан хаагчдаар бүрдүүлэх, тэднийг ажлын байранд нь давтан сургах, дадлагажуулах ажлыг үе шаттай зохион байгуулж, тогтвор суурьшилтай | Төрийн албан хаагчдын мэдлэг, чадварыг дээшлүүлэх, нийгмийн баталгаар хангах арга хэмжээний 2021-2024 онд хэрэгжүүлэх хөтөлбөрийг боловсруулж Тамгын газрын даргын 2022 оны А07 тоот тушаалаар баталсан. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө гаргаж хэрэгжилтийг 91.3 хувийн биелэлттэй гүйцэтгэсэн. Төлөвлөгөөний хүрээнд албан хаагчдын ур чадвар, чадавхыг дээшлүүлэх зорилгоор 10 удаагийн дотоодын мөн бусад байгууллагаас 3 удаагийн сургалтыг зохион байгуулан, давхардсан тоогоор 200 албан хаагч, Удирдлагын академийн богино хугацааны сургалтад 2 албан хаагч, хамрагдсан. Мөн 3 | 91.3 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | ажиллуулна \Сургалтын тоо\ | албан хаагчид дотоод журмын дагуу 1,250,0 төгрөгийн дэмжлэг тусламж үзүүлэн, албан хаагчдын дархлааг дэмжих зорилгоор 27 албан хаагчдад 680,0 төгрөгийн витаминжуулалтын багц олгосон. **Хүрсэн түвшин: Төлөвлөгөөний хэрэгжидтийн хувь-91,3** | |
| 56 | | 5.2.2 Авлигаас урьдчилан сэргийлэх, олон нийтийг соён гэгээрүүлэх үйл ажиллагааг зохион байгуулна. | Тухайн жилийн төлөвлөгөөний хэрэгжилт-100% | Авлигаас урьдчилан сэргийлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт хангагдана. | Авлигаас урьдчилан сэргийлэх, олон нийтийг соён гэгээрүүлэх чиглэлээр 2022 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг гарган төлөвлөгөөний хүрээнд АТГ-аас бэлтгэсэн тв шторк, инфографик, видео график, нийтлэл, теле зохиомж, хөдөлгөөнт зураг, зурагт хуудас, цахим ном, гарын авлага зэрэг 8 төрлийн мэдээ мэдээллийг байгууллагын албан ёсны цахим хуудас болон нийгмийн сүлжээ /фэйсбүүк/-д байршуулан иргэдэд хүргэсэн. Мөн Авлигатай тэмцэх газраас зохион байгуулсан иргэдэд зориулсан соён гэгээрүүлэх өдөрлөгт албан хаагчид оролцож, ажлын хэсэгтэй хамтран зах худалдааны төвүүдээр орж 200 иргэдэд танилцуулга мэдээлэл өгсөн. Төрийн захиргааны ажилтнуудын ХАСХОМ-ийг хүлээн авч баталгаажуулан хугацаанд нь тайлагнасан. **Хүрсэн түвшин: Хэрэгжилтийн хувь 80** | 80 |
| **5.3 Иргэдийн аюулгүй, амар тайван байдлыг хангана.** | | | | | | |
| 57 | Иргэдийн амгалан тайван, аюулгүй орчинд амьдрах нөхцлийг бүрдүүлж, олон нийтийн оролцоог нэмэгдүүлнэ. | 5.3.1 Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгмийн хэв журмыг сахиулах ажлыг чанаржуулан, иргэдийн амар тайван амьдрах нөхцлийг бүрдүүлнэ. | Тухайн жилийн төлөвлөгөөний | Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын чанар сайжирна. | Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх төлөвлөгөө гаргаж батлуулан төлөвлөгөөний дагуу аймгийн Цагдаагийн хэлтэс болон Мэргэжлийн хяналтын газартай хамтран хөдөөгийн багийн нутаг дэвсгэрт 4 удаагийн эргүүл хяналт шалгалт зохион байгуулж, өөр аймаг сумын отроор ирсэн 40 айл өрхөөр орж засаг даргын мэдэгдлийг хүргүүлж хугацаандаа нүүх талаар сануулж, мөн 44 айлаар өрхөөр орж бэлчээр ашиглалтын журам танилцуулж, гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, зөвшөөрөлгүй ан амьтан агнах, Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар зөвлөмж хүргэж иргэдтэй санал бодлыг нь сонсож ажиллаа. Мөн | 80 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | хэрэгжилт - 100% | | Сумын хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг аж ахуй нэгж байгууллагуудын мэдээллийн самбарт гэмт, хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх зурагт хуудас, санамж сэрэмжлүүлгийг байршуулан, ажилтан албан хаагчдад гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар мэдээ мэдээлэл холбогдох хууль тогтоомжийг танилцуулж, эрх бүхий байгууллагаас гаргасан шийдвэр тогтоомжийг мөрдлөг болгон ажиллах үүрэг чиглэлийг багийн Засаг дарга нар биечлэн мэдэгдэж, мөн гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгдэж болзошгүй, ахуйн хүрээний архидалттай болон архины сайн дурын эмчилгээнд хамрагдсан айл өрхүүдээр хэсгийн байцаагч нарын хамтаар орж хяналт тавьж ажилласан. Мөн Хүүхэд эмэгтэйчүүдийн бэлгийн мөлжлөг, хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх сургалтыг 1,2,5-р сургуулийн ахлах ангийн 481 сурагчид 3 удаагийн сургалтыг зохион байгуулж ажиллалаа<br>**Хүрсэн түвшин:**<br>**Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь- 80**<br>**Хяналт шалгалтын тоо-5** | |
| 58 | | 5.3.2 Иргэдийн гамшгаас хамгаалах мэдлэг чадварыг бататгахад чиглэсэн дадлага сургалтыг тасралтгүй явуулах, гамшгийн хор уршгийг арилгах, аврах зориулалттай тусгай багаж, тоног төхөөрөмж, техник хэрэгслийн хангамжийг сайжруулах, болзошгүй гамшиг эрсдэлийн үед хэрэглэх хүнсний гол нэрийн барааны орон нутгийн нөөц бүрдүүлнэ | Гамшгаас хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлнэ. Иргэдийн гамшгаас хамгаалах мэдлэг чадварыг дээшлүүлэх сургалт-1 удаа Сайн дурын бүлгийн сургалт-1 ЕЗМА-ын албан хаагчдад дадлага олгох сургалт-1 | Гамшиг ослоос урьдчилан сэргийлэх арга хэмжээ сайжирна. | Иргэдийн гамшгаас хамгаалах мэдлэг чадварыг дээшлүүлэх зорилгоор 5-р багийн 10 бүлгийн 120 малчинд 1 удаагийн сургалт зохион байгуулсан. 4-р багийн 7 бүлгийн 105 малчинд 2 удаагийн, 6-р багийн 12 бүлгийн 144 малчинд 2 удаагийн сургалт зохион байгуулж чадавхжуулсан Сумын мэргэжлийн ангийн сайн дурын бүлгийн 15 гишүүнийг тодотгож, гамшгаас хамгаалах арга хэмжээний зардлаас хувцас, аранз, үүргэвчийг шинээр авахаар 3,0 сая төгрөгийн төсөв батлуулсан. ЗГ-н 339-р тогтоолоор баталсан захирамжийн дагуу 4-р сард Гамшгаас хамгаалах төлөвлөгөө тодотгох, сумын ерөнхий зориулалтын Мэргэжлийн ангийн үүрэг гүйцэтгэх чадавхийг нэмэгдүүлэх арга хэмжээнд гал түймрийн аюул, газар хөдлөлтийн үеийн дадлага | 100 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | сургуулилтын сургалтанд 24 ажилтан албан хаагч хамрагдсан. Байгууллагын "Галын аюулгүй ажиллагааг хангах төлөвлөгөө аюулгүй ажиллгааны дүрэм журам"-н дагуу ажлын хүрээнд галын багаж хэрэгслийн жагсаалт шинэчлэн гаргаж, ажилтан албан хаагчдыг гал түймэр гарсан үеийн томилгоог тодотгож, томилгоот мэргэжлийн ангийн гишүүд гамшгийн үед зайлшгүй шаардагдах багаж хэрэгсэл, хувийн бэлтгэл, эд зүйлсийг багтаасан аранзыг үүрч "Цуглах цэг" бүсэд жагсаж, дадлага сургуулилтын үзлэгт хээрийн бэлтгэл аранз үүргэвчийн бүрэн байдлыг хангаж ажилласан Аймгийн гамшгийн эрсдлийг бууруулах зөвлөлийн гишүүдэд гамшгаас хамгаалах чиглэлээр ОБГазар дээр 3-р сард хийгдсэн " орон нутагт эрсдлийн үнэлгээ хийх " тухай сургалтанд 2 албан хаагч, 1-р сард зохион байгуулсан "Халдвараас урьдчилан сэргийлэх хариу арга хэмжээ авах" тухай сургалтанд 1 албан хаагч хамрагдсан.<br>**Хүрсэн түвшин: Сайн дурын хэсгийг Хөдөлмөр хамгааллын хувцсаар хангахаар 3 сая төгрөг батлуулсан**<br>**Зохион байгуулсан сургалт- 5**<br>**ЕЗМА-ын албан хаагчдад дадлага олгох сургалт-1** | |
| 59 | | 5.3.3 Хууль тогтоомжийг сурталчлах, эрх зүйн мэдээ, мэдээллээр хангах эрх зүйн хөтөч буланг сумын нэг цонхны үйлчилгээний төвд байгуулж, иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлнэ. | Тухайн жилийн төлөвлөгөөний хэрэгжилт - 100%<br>Иргэдийн сургалтыг сард -1 удаа зохион байгуулна. | Иргэдийн хууль эрх зүйн мэдлэг дээшилсэн байна. | Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх зорилгоор сумын Засаг даргын Тамгын газрын 1 давхарт эрх зүйн хөтөч булан ажиллуулан www.e-khutuch.mn эрх зүйн цахим хөтчөөр дамжуулан 110 иргэнд мэдээлэл хүргэн ажилласан ба аймгийн Хууль эрх зүйн хэлтсээс зохион байгуулах эрх зүйн хөтөч бэлтгэх сургалтад 3 албан хаагчийг хамруулахаар судалгааг хүргүүлсэн.<br>**Хүрсэн түвшин:**<br>**Төлөвлөгөөний хэрэгжилт хувь-70**<br>**Бэлтгэгдсэн сургагч багшийн тоо-0** | 70 |
| **5.4. Тогтвортой, нэгдмэл гадаад бодлого** | | | | | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 60 | Олон улс, бүс нутгийн түвшинд хамтын ажиллагааг өргөжүүлнэ | Гадаад хамтын ажиллагааг хөгжүүлэх арга хэмжээг хэрэгжүүлж, Олон улс, бүс нутгийн түвшинд хамтын ажиллагааг өргөжүүлэн, төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүдийг гадаад хамтын ажиллагааны хүрээнд үйл ажиллагаагаа өргөжүүлэхэд нь бодлогоор дэмжинэ. | Гүйцэтгэлээр | Хамтран ажиллах байгууллагын тоо | Дэлхийн зөн олон улсын байгууллага Бор-Өндөр 1 орон нутгийн хөтөлбөртэй хамтран аюулгүй хишиг гудамж төсөл, малжуулах төслийг амжилттай зохион байгуулан, Малжуулах төслийн хүрээнд амьдралын баталгаажих түвшнээс доогуур орлоготой мал маллах сонирхолтой 15 өрхийг тус бүр 20 хургатай хониор малжуулан ажиллалаа. Японы хүүхдийг ивээх сангийн тусламжтай хэрэгжиж буй өсвөр залуу үеийнхэнд интерпренершипийн боловсрол олгох төслийн Сүмбэр сумын ерөнхий боловсролын 1 сургуулийн 8-12 ангийн сурагчид, насан туршийн боловсролын төвийн сурагчдыг хамруулан амжилттай хэрэгжүүлж байна. Тус төслийн сургалтад 2 удаа 300 сурагч хамрагдан төгсөж байгаа бөгөөд 3 төсөл эхний шатны санхүүгийн дэмжлэг буюу 5400000төгрөгийг авсан ба 2 дахь төгсөлтийн 15 төсөл 2 дахь шатны шалгаруулалтад оролцож байна.<br>**Хүрсэн түвшин: 80** | 80 |
| **Батлан хамгаалах** | | | | | | |
| **5.5. Орон нутгийн хамгаалалтын тогтолцоог бэхжүүлж, дайчилгааны төлөвлөлтийг шинэчилнэ.** | | | | | | |
| 61 | Нутаг дэвсгэртээ батлан хамгаалах хууль тогтоомжийг сурталчлах, хэрэгжилтийг хангах | 5.5.1 Батлан хамгаалахын хууль тогтоомжийн хэрэгжилтийг эрчимжүүлж, орон нутгийн хамгаалалтын тогтолцоог бүрдүүлж, дайчилгааны төлөвлөгөөний хэрэгжилтийг хангана | Жилд 3 удаа Шинэчилсэн бүртгэл -1<br>Цэрэг татлага - 2<br>Орон нутгийн хамгаалалтын төлөвлөгөөний бие бүрэлдэхүүний томилгоожуулалтыг тухай бүрт нь шинэчлэнэ. | Хуулийн хэрэгжилт хангагдана. | Цэрэг татлага зохион байгуулахтай холбоотойгоор багийн Засаг дарга нар болон нийгмийн ажилтан нарт аймгийн цэргийн штабаас Батлан хамгаалах хуулиар мэдээлэл өгч, арга зүйгээр хангасан. Орон нутгийн хамгаалалтын төлөвлөгөөний хавсралт мэргэжлийн сумангийн удирдлагын томилгоог тодотгож аймгийн цэргийн штабт хүргүүлсэн.<br>**Хүрсэн түвшин: Дайчилгааны төлөвлөлтийг шинэчилсэн** | 100 |
| 62 | | 5.5.2 "Хүүхэд, залуучуудад эх оронч үзэл төлөвшүүлэх арга хэмжээ"-г хэрэгжүүлнэ. | Цэргийн насны залуучуудыг эрүүлжүүлэх ажлыг -1 удаа | Цэргийн насны болон өсвөр насны дунд эх оронч үзэл, хүмүүжил | 1-р ээлжийн цэрэг татлага зохион байгуулагдаагүй бөгөөд багийн иргэдийн нийтийн хурал багийн өдөрлөг дээр цэргийн насны иргэдийг цуглуулж Өрхийн эрүүл мэндийн төвтэй хамтран эрүүлжүүлэх, | 30 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | Эх оронч үзэл хүмүүжил төлөвшүүлэх ажил зохион байгуулах -1 удаа | олгоход чиглэсэн ажил зохион байгуулагдсан байна. | өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч ажиллаж байна.<br>**Хүрсэн түвшин: урьдчилан сэргийлэх үзлэгт-31 иргэн** | |
| **ЗУРГАА.НОГООН ХӨГЖЛИЙН БОДЛОГО** | | | | | | |
| **Ногоон хөгжил** | | | | | | |
| **6.1 Байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг зүй зохистой ашиглаж, дэвшилтэт техник, технологи нэвтрүүлж, хүрээлэн буй орчны бохирдол, доройтлыг бууруулж, иргэдийн эрүүл орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ.** | | | | | | |
| 63 | Ногоон бүс, ойн зурвас байгуулан газрын хөрсийг нөхөн сэргээх замаар байгаль орчны доройтлыг сааруулна. | 6.1.1 "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөнийг зохион байгуулан, ногоон байгууламжийг нэмэгдүүлж, иргэдийн оролцоог хангаж ажиллана. | Гүйцэтгэлээр | Иргэдийн оролцоо нэмэгдсэн байна. | "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд сумын хэмжээнд мод тарих хөдөлгөөн 05 сарын 27 хүртэл үргэлжлэх ба 05 сарын 20-ны байдлаар хаврын мод тарилтын ажлыг төрийн 34 байгууллага 1040 мод, хувийн хэвшлийн 11 байгууллага 608 мод, сумын 6 багийн 204 иргэн 1008 мод, замын баруун талд үйлдвэрлэлийн зориулалтаар үйл ажиллагаа явуулж буй 18 байгууллагаас 5 байгууллага 1500 мод нийт 50 ААН байгууллага 4156 мод шинээр тарьсан. Тарьсан модны нахиа задралт 50 хувьтай байна.<br>**Хүрсэн түвшин:**<br>**Зохион байгуулсан арга хэмжээний тоо 5 удаагийн уулзалт ярилцлага хийсэн.**<br>**Шинээр тарьсан модны тоо 4156**<br>**Ургалтын хувь / нахиа задарсан байдал /-50**<br>**Хамрагдсан иргэдийн тоо- 204**<br>**Хамрагдсан ААНБ-ын тоо- 50** | 100 |
| 64 | | 6.1.2 Булаг шандны эхийг хамгаалж, тохижуулах ажлыг үргэлжлүүлнэ. | Булаг шандын цэвэрлэгээ -1<br>Булаг шандны эхийг хамгаалах -1 арга хэмжээ | 4,5 дугаар багт булаг шандын цэвэрлэгээг зохион байгуулсан байна.<br>6-р багийн "Сайн ус" булгийг хашиж хамгаалсан байна. | Энэ оны 01.23, 03.06-ны өдрүүдэд сумын 4, 5-р багийн нутаг дэвсгэр Уулзварын гол, Асгана булаг, Дунд уул, Дарь эх, Цоорхойн рашаан, Хүрээ ногоон гэсэн маршрутын дагуу 8 хүний бүрэлдэхүүнтэй цэвэрлэгээг зохион байгуулж, 14 тонн хог хаягдлыг төвлөрсөн хогийн цэгт төвлөрүүлэн ажиллалаа.<br>**Хүрсэн түвшин:**<br>Зохион байгуулсан цэвэрлэгээний тоо- 2<br>Хог хаягдлын хэмжээ- 14тн | 100 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 65 | | 6.1.3 Сумын ус түгээх цэгийн ойролцоох 100 метр талбайд байрлах айл өрхүүдийн нүхэн жорлонг стандартын шаардлага хангасан, хөрсөнд нэвчдэггүй био нойлтой болгох ажлыг үе шаттай хэрэгжүүлнэ. | Гүйцэтгэлээр | 2,3-р багийн айл өрхийн нүхэн жорлонд MNS 5924:2015 стандартыг мөрдүүлж, доторлогоотой бие засах газартай болгосон байна. | Ундны усны эх үүсвэр болон ус түгээх байрнуудын эрүүл ахуйн бүсэд байрлаж байгаа айл өрхүүдийг стандартын шаардлага хангасан доторлогоотой бие засах газартай болгох талаар гарын авлага бэлтгэж 50ш тараасан. 2 айл жорлонгоо өөрчилсөн.<br>**Хүрсэн түвшин:**<br>**Шинээр бий болсон стандартын шаардлага хангасан жорлонгийн тоо-2**<br>**Зохион байгуулсан арга хэмжээний тоо 1** | 50 |
| 66 | | 6.1.4 Тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын үйл ажиллагаанд орон нутгийн иргэд, бүлгүүдийг татан оролцуулна. | Гүйцэтгэлээр | Тусгай хамгаалалттай газрууд байгаль хамгаалах бүлгүүдийн хяналтанд бүрэн хамгаалагдана. | Тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын үйл ажиллагаанд орон нутгийн байгаль хамгаалах бүлгүүдийн үйл ажиллагааг идэвхижүүлэх ажил арга хэмжээг 3 дугаар улиралд зохион байгуулахаар төлөвлөсөн.<br>**Хүрсэн түвшин:**<br>**Хэрэгжүүлэхээр төлөвлөсөн** | 30 |
| 67 | Байгаль орчныг хамгаалж, байгалийн нөөц баялгийг зохистой ашилан ашиглалтыг сайжруулахад олон нийтийн оролцоог хангана. | 6.1.5 Тууpь, хур хог хаягдал бүхий талбайн хэмжээг үе шаттайгаар цэвэрлэх ажлыг зохион байгуулж, нийгмийн хариуцлагын хүрээнд иргэд ААНБ-тай гэрээ байгуулан оролцоог хангуулна. | Цэвэрлэх тууpь балгас, хур хог хаягдал бүхий талбайн хэмжээ 10 га | Хог хаягдлын хэмжээ багассан байна. Нийгмийн хариуцлагын хүрээнд иргэд ААНБайгууллагуудыг татан оролцуулна. | Тууpь, хур хог хаягдал бүхий талбайн хэмжээг үе шаттайгаар цэвэрлэх ажлыг нийгмийн хариуцлагын хүрээнд иргэд, ААНБ-ыг татан оролцуулан 4,5 га талбайг цэвэрлэж хөрсийг эрүүлжүүлээд байна. Мөн 3-р багийн Баянбулгын айл өрхийн хашааны ар талын элсийг түрж, ачиж тээвэрлэсэн.<br>**Хүрсэн түвшин:**<br>**Цэвэрлэсэн талбайн хэмжээ 4,5га** | 70 |
| 68 | | 6.1.6 Нэн ховор, ховор амьтан, ургамлын нөөц, ховордсон зүйлийг хамгаалж, нөхөн сэргээн нутагшуулах, биотехникийн арга хэмжээ авч хэрэгжүүлнэ | Биотехникийн арга хэмжээг -2 удаа зохион байгуулна. | /Өвс, хужир тавих/ | ШШГГ нээлттэй 425-р анги, "Боржигин булаг хоршоо"-той хамтран Улсын Тусгай хамгаалттай Чойрын богд ууланд 50 боодол өвс, 10 шуудай хужир 4 цэгт тараан байршуулж ажиллалаа.<br>**Хүрсэн түвшин:**<br>**Зохион байгуулсан арга хэмжээний тоо- 1** | 100 |
| 69 | | 6.1.7 "Тохижилт Сүмбэр" ОНӨААТҮГ-ын үйл ажиллагаа, менежментийг сайжруулж, ажлыг үр дүнгээр тооцоо хийдэг тогтолцоог хэвшүүлнэ. | Гүйцэтгэлээр | Ажлын үр дүн дээшилсэн байна. | Сумын хэмжээнд хог хаягдлын менежментийг тогтолцоог сайжруулах зорилгоор сумын Засаг даргын А/56 тоот захирамжаар 13 гишүүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг байгулагдаж 2 удаагийн уулзалт ярилцлага зохион байгуулсан. Иргэдийн | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | дунд 2 удаагийн уулзалт хийснээр дахивар авдаг иргэдийг нэгтгэж "Чойр дахивар эрдэнэ" хоршоог иргэдийн төлөөллөөр байгуулж, дахивар авах цэгийг 1-р баг Төрийн банкны хойд тал, 3-р баг хуучин Онцгой байдлын газрын байранд цэгийг байгуулахаар болсон. Мөн "Өнгө нэм" ТББ-тай хамтран сумын хэмжээнд хог хаягдлын тогтвортой менежментийн тогтолцоог бий болгох зорилгоор ОНХС-ийн 10,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 6 сарын хугацаатай "Хог хаягдлын менежментийн тогтвортой хэрэгжүүлэх" төсөлд хамтран ажиллах гэрээ байгуулж, суурь судалгааг бүрэн хийгдэж төлөвлөлтийн шатанд явагдаж байна. Сум хэмжээнд "Дахивар авах өдөрлөг", "Зүгээр битгий хая" аяныг зохион байгуулсан<br>Тохижилт Сүмбэр ОНӨААТҮГ-т сумын ОНХС-ийн хөрөнгөөр ковш машин худалдаж авахаар тендер зарласан. 6 дугаар сард авна.<br>**Хүрсэн түвшин:**<br>**Зохион байгуулсан арга хэмжээний тоо 3**<br>**Байгуулсан цэгийн тоо 2**<br>**Гүйцэтгэлийн хувь 86** | 86 |
| 70 | | 6.1.8 Нохой, муур тэжээх, арчлах, золбин нохой устгах журмын хэрэгжилтийг хангаж ажиллана. | Нохой устгал-2 удаа | Нохойны бүртгэл судалгаа гаргаж, золбин нохой муур тэжээх, устгах журмыг ИТХ-аар батлуулж мөрдүүлсэн байна. | Сумын Засаг даргын 04.15-ны өдрийн А/67 дугаар захирамжийн дагуу "Тохижилт Сүмбэр" ОНӨААТҮГазар нь золбин нохой, муур устгалын ажлыг 04.18-20-ний өдрийн хооронд зохион байгуулж, 311 золбин нохой, 32 муурыг 6.860.000 төгрөгийг зарцуулан устгаж төвлөрсөн хогийн цэгт төвлөрүүлж, ариутгал хийн булж ажилласан.<br>**Хүрсэн түвшин:**<br>**Устгасан нохойны тоо – 311**<br>**Устгасан муурны тоо – 32**<br>**Зохион байгуулсан арга хэмжээний тоо 1.** | 100 |
| 71 | | 6.1.9 Түгээмэл тархацтай ашигт малтмалын нөөцийн талаар судлан, гэрээ байгуулж, олборлолт явуулсан газарт | Гүйцэтгэлээр | Олборлолт хийгдсэн газарт нөхөн сэргээлтийг тухай бүрт нь хийлгэнэ. | Эхний хагас жилийн байдлаар түгээмэл тархацтай ашигт малтмал ашиглуулах гэрээг 5 иргэн, 7 компанитай байгуулж, 2745м$^3$ шар шороо, 398м$^3$ хайрга, 30м$^3$ элс олборлож, | 100 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | техникийн нөхөн сэргээлт хийх ажлыг зохион байгуулна. | | | 18,597,500 төгрөгийг орон нутгийн орлогод төвлөрүүлээд байна. 3<br>**Хүрсэн түвшин:** Нөхөн сэргээлт хийсэн газрын хэмжээ- 2.4 га | |
| 72 | | 6.1.10 Байгаль хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлнэ | Гүйцэтгэлээр | Арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт-100% | 2022 онд байгаль хамгаалах арга хэмжээний зардалд 55 сая төгрөг батлагдсан. Төсвийн задаргааг Засаг даргын захирамжаар батлуулан хэрэгжүүлж байна. Нийт 9 арга хэмжээ төлөвлөгдсөнөөс 4 арга хэмжээ бүрэн хэрэгжиж 37 сая төгрөг зарцуулаад байна. | **80** |
| **ДОЛОО. ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО** | | | | | | |
| **7.Сумын төвийн хөгжлийг дэмжиж, дэд бүтцийг хөгжүүлнэ** | | | | | | |
| 73 | Хот суурин газрын дэд бүтцийг нэмэгдүүлж, иргэдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах нөхцлийг бүрдүүлэн, хот тохижилтыг сайжруулна. | 7.1 Шинэ суурьшлын бүсэд цахилгаан татах | Гүйцэтгэлээр | ОНХСан 150,0 сая | Шинэ суурьшлын бүсэд цахилгаан татах ажлын техникийн тодорхойлолт боловсруулж байна.<br>**Хүрсэн түвшин: Теникийн тодорхойлолт боловсруулагдаж байгаа.** | 30 |
| 74 | | 7.2 3 дугаар багийн Гашууны эгнээнд худаг гаргах | Гүйцэтгэлээр | ОНХСан 100,0 сая | Шинэ суурьшлын бүсэд худаг гаргах ажлын тендерийг 2022 оны 03 сарын 29-ны өдөр төрийн худалдан авах ажиллагааны цахим системээр зарласан.<br>**Хүрсэн түвшин: Тендер зарлагдсан**. | 50 |
| 75 | | 7.3 1 дүгээр багийн дан байрнуудын цэвэр бохир усны шугам татах | Гүйцэтгэлээр | ОНХСан 140,0 сая | 1-р багийн дан байрнуудын цэвэр бохир усны шугам татах ажлын техникийн тодорхойлолтыг боловсруулж байна.<br>**Хүрсэн түвшин: Техникийн тодорхойлолт боловсруулагдаж байгаа.** | 30 |
| 76 | | 7.4 3 дугаар багийн Баянбулагийн эгнээнд гэрэлтүүлэг тавих | Гүйцэтгэлээр | ОНХСан 70,0 сая | 3-р багийн нутаг дэвсгэр Баянбулагийн эгнээнд гэрэлтүүлэг хийх ажлын тендерийг 2022 оны 03 сарын 29-ны өдөр төрийн худалдан авах ажиллагааны цахим системээр зарласан.<br>**Хүрсэн түвшин: Тендер зарлагдсан.** | 50 |
| 77 | | 7.5 "Тохижилт Сүмбэр" ОНӨААТҮГ-т хог хаягдал түрэх, зөөвөрлөх ковш машин худалдан авна. | Гүйцэтгэлээр | ОНХСан 195,0 сая | Хог хаягдал түрэх, зөөвөрлөх ковш авто машин худалдан авах ажлын тендер шалгаруулалтыг зохион байгуулж "Петротрак"ХХК-д гэрээ байгуулах мэдэгдлийг хүргүүлсэн.<br>**Хүрсэн түвшин: Гэрээ байгуулсан**. | 70 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 78 | | 7.6 5 дугаар сургуулийн мэдээлэл зүйн кабинетийн тоног төхөөрөмжийг шинэчлэх | Гүйцэтгэлээр | Сумын ОНХСан 40,0 сая | 5-р сургуулийн мэдээлэл зүйн кабинетын тоног төхөөрөмж шинэчлэх ажлын тендер шалгаруулалтыг зохион байгуулж, 6 нэр төрлийн 20 тоног төхөөрөмжийг нийлүүлэхээр "Монтех дистрибьюшн" ХХК-тай 2022 оны 03 сарын 16-ны өдөр гэрээ байгуулсан. **Хүрсэн түвшин: Гэрээ байгуулсан.** | 70 |
| 79 | | 7.7 1,2 дугаар сургуулийн гал тогооны тоног төхөөрөмжийг шинэчлэх | Гүйцэтгэлээр | Сумын ОНХСан 20,0 сая | Шууд худалдан авалтын ажлын хүрээнд 1,2 сургуулийн 11 нэр төрлийн гал тогооны тоног төхөөрөмжийг нийлүүлэхээр "Чиглэл тоног төхөөрөмж", "Тулга төхөөрөмж" ХХК-уудтай 2022 оны 03 сарын 14-ны өдөр гэрээ байгуулсан. Тус ажлыг 2022 оны 03 сарын 31-ны өдөр ажлын хэсгийн бүрэлдэхүүн хүлээн авж 2 сургуульд 10 нэр төрлийн гал тогооны тоног төхөөрөмж, 1-р сургуульд нэржин 2-р хоолны 250 ширхэг тавгийг тус тус хүлээлгэн өгсөн. **Хүрсэн түвшин**: **Гүйцэтгэлийн хувь-100** | 100 |
| 80 | | 7.8 Цагдаагийн хэлтэст суудлын авто машин худалдан авах | Гүйцэтгэлээр | Сумын ОНХСан 25,0 сая | Тендер шалгаруулалтын ажлын зохион байгуулж, цагдаагийн хэлтэст суудлын авто машиныг 2022 оны 03 сарын 07-ны өдөр цагдаагийн нийтийн хэв журмыг хамгаалах тасагт хүлээлгэн өгсөн. **Хүрсэн түвшин**: **Гүйцэтгэлийн хувь-100** | 100 |
| 81 | | 7.9 Сумын ЗДТГ-ын барилгын их засвар | Гүйцэтгэлээр | Сумын ОНХСан 350,0 сая | Сүмбэр сумын Засаг даргын Тамгын газрын барилгын их засварын ажлын тендерийг төрийн худалдан авах ажиллагааны цахим системээр 2022 оны 03 сарын 21-ны өдөр зарласан. **Хүрсэн түвшин:** Тендер зарлагдсан. | 50 |

## 2021 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН БИЕЛЭЛТИЙН ТОВЧОО

| № | Бодлогын зорилтын нэр | Салбарын зорилт | Арга хэмжээний тоо | Дундаж үнэлгээний хувь |
|---|---|---|---|---|
| 1. | **НЭГ. "КОВИД-19" ХАЛДВАРТ ЦАР ТАХЛААС ҮҮДЭЛТЭЙ ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ХҮНДРЭЛИЙГ ДАВАН ТУУЛАХ БОДЛОГО** | 1.1 "Ковид-19" халдварт цар тахлаас үүдэлтэй эдийн засаг, нийгмийн хүндрэлийг даван туулах бодлогын арга хэмжээг хэрэгжүүлэх | 3 | **86.6** |
| **Бодлогын зорилтын хэсгийн дундаж үнэлгээ** | | | **3** | **86.6** |
| 2. | **ХОЁР. ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО** | Эрүүл мэнд<br>2.1. Иргэдийн эрүүл мэндин боловсролыг дээшлүүлж, урьдчилан сэргийлэх тогтолцоог сайжруулан, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлнэ. | 3 | 89 |
| 3. | | Биеийн тамир, спорт<br>2.2. Нийтийн биеийн тамир, эрүүл, идэвхтэй амьдралын хэв маягийг хөгжүүлж, тамирчдын өрсөлдөх чадвар, амжилтыг нэмэгдүүлнэ | 2 | 100 |
| 4. | | Боловсрол<br>2.3. Боловсролын үйлчилгээнд тэгш хамруулж, чанар хүртээмжийг сайжруулна | 3 | 100 |
| 5. | | Хөдөлмөр, нийгмийн хамгаалал<br>2.4. Хүн амын хөгжлийг хангаж, хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, ажилгүйдэл ядуурлыг бууруулна. | 9 | 80.5 |
| 6. | | Үндэсний бахархал, өв соёл<br>2.5. Үндэсний үнэт зүйл, уламжлалт өв соёлоо дээдэлж, иргэдийг соён гэгээрүүлж, соёл урлагийн байгууллагуудын үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлнэ. | 4 | 62.5 |
| **Бодлогын зорилтын хэсгийн дундаж үнэлгээ** | | | **21** | **86.4** |
| 7. | **ГУРАВ. ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО** | Санхүү, төсвийн зохицуулалт<br>3.1. Санхүү, эдийн засгийн нээлттэй, ил тод байдлыг хангах бодлого хэрэгжүүлнэ. | 3 | 86.6 |
| **Бодлогын зорилтын хэсгийн дундаж үнэлгээ** | | | **3** | **86.6** |
| 8. | **ДӨРӨВ. ХӨДӨӨ АЖ АХУЙН БОДЛОГО** | 4.1 Малын чанар, ашиг шимийг сайжруулж, малын тоог чанарт шилжүүлж малын генийн санг хамгаалах, биотехнологийн ололтыг нэвтрүүлэх, эрчимжсэн мал аж ахуйн салбарын хөгжлийг дэмжинэ | 7 | 72.1 |
| 9. | | Хоршоо, ахуйн үйлчилгээ<br>4.2 Хоршоо ахуйн үйлчилгээ эрхлэгчдийг чадавхижуулж, ажлын байрыг нэмэгдүүлэх, орон нутгийн брэндийг хөгжүүлэн, бичил үйлдвэрлэлийг дэмжин ажиллана. | 2 | 85 |
| 10. | | Хүнсний аюулгүй байдал<br>4.3 Хүнсний үйлдвэрлэлийг дэмжиж, хүнсний аюулгүйт байдлыг хангаж ажиллана. | 3 | 63.3 |
| 11. | | Газар тариалангийн үйлдвэрлэл<br>4.4.Бэлчээрийн менежментийн тогтвортой байдлыг хангах, тариалангийн үйлдвэрлэлийн нөөц ашиглалтыг сайжруулж, төмс, хүнсний ногооны хангамжийн хувь хэмжээг нэмэгдүүлнэ. | 7 | 60 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 12. | | Аялал жуулчлал<br>4.5. Орон нутгийн онцлог, нутгийн иргэдэд түшиглэсэн тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлнэ | 1 | 30 |
| 13. | | Барилга, хот байгуулалт<br>4.6. Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын салбарыг орон нутагт хөгжүүлж, иргэдийн орон сууцны хангамжийг нэмэгдүүлнэ | 3 | 56.6 |
| **Бодлогын зорилтын хэсгийн дундаж үнэлгээ** | | | **23** | **61.1** |
| 14. | **Тав. ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО** | "Цахим Монгол"- төрийн шуурхай үйлчилгээ<br>5.1. Мэдээллийн аюулгүй байдлыг хангасан цахим орчныг бүрдүүлэн, ил тод байдлыг хангаж, иргэд, олон нийтэд мэдээ, мэдээлэл, төрийн үйлчилгээг шуурхай, хариуцлагатай, хүртээмжтэй хүргэх орчин нөхцөлийг бүрдүүлнэ. | 4 | 85 |
| 15. | | Мэргэшсэн, хариуцлагатай төрийн алба<br>5.2. Нутгийн захиргааны байгууллагуудыг чадавхжуулж, төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийгсайжруулж, төрийн албан хаагчдын ёс зүй, хариуцлагыг дээшлүүлнэ. | 2 | 85.6 |
| 16. | | Амар тайван, аюулгүй нийгэм<br>5.3. Иргэдийн аюулгүй, амар тайван байдлыг хангана. | 3 | 83.3 |
| 17. | | Тогтвортой, нэгдмэл гадаад бодлого<br>5.4. Гадаад харилцаанд нэг цонхны нэгдмэл бодлогыг хэрэгжүүлэн, хөрш орнууд болон гуравдагч хөрш орнуудтай худалдаа, эдийн засгийн харилцааг өргөжүүлэх | 1 | 80 |
| 18. | | Батлан хамгаалах<br>5.5. Орон нутгийн хамгаалалтын тогтолцоог бэхжүүлж, дайчилгааны төлөвлөлтийг шинэчилнэ. | 2 | 65 |
| **Бодлогын зорилтын хэсгийн дундаж үнэлгээ** | | | **12** | **80,0** |
| 19. | **Зургаа. НОГООН ХӨГЖЛИЙН БОДЛОГО** | Ногоон хөгжил<br>6.1. Байгаль орчныг хамгаалах, байгалийн баялагийг зүй зохистой ашиглаж, дэвшилтэт техник, технологи нэвтрүүлж, хүрээлэн буй орчны бохирдол, доройтлыг бууруулж, иргэдийн эрүүл орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ. | 10 | 81.6 |
| | **Бодлогын зорилтын хэсгийн дундаж үнэлгээ** | | **10** | **81.6** |
| 20. | **Долоо. ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО** | Сумын төвийн хөгжил<br>7.1. Аймаг, сумдын төвийн хөгжлийг дэмжиж, дэд бүтцийг хөгжүүлэн, орон нутгийн иргэдийн амьдралын чанарыг дээшлүүлнэ. | 9 | 61.1 |
| **Бодлогын зорилтын хэсгийн дундаж үнэлгээ** | | | **9** | **61.1** |
| **ДҮГНЭЛТ** | | **Нийт 7 бодлогын 20 салбарыг хөгжүүлэх зорилтын 101 арга хэмжээний ерөнхий дундаж үнэлгээ** | **81** | **79.1** |

ТАЙЛАН НЭГТГЭСЭН:

ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ Н.ХИШИГДОРЖ